

ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬ
/Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилго

1.1.Энэхүү хуулийн зорилго нь төмөр замын дэд бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнийг өмчлөх, эзэмших, ашиглах, нэгдсэн зурмагаар зорчигч, ачаа тээвэрлэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Төмөр замын тээврийн тухай хууль тогтоомж

2.1.Төмөр замын тээврийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Хөдөлмөрийн тухай хууль, энэ хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжоос бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хуулиар өмчийн төрөл, хэлбэр харгалзахгүй төмөр замын тээврийн үйл ажиллагааг зохицуулна.

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“**ачаа**” гэж тогтоосон журмын дагуу цаг тухайд нь хүргэх, бүрэн бүтэн байдлыг нь хангаж төмөр замаар тээвэрлэхээр тээвэрлэлтэд хүлээж авсан ашигт малтмал, эд хөрөнгийг;

4.1.2.“**ачаа илгээгч**” гэж өөрийн болон ачаа, тээш, ачаан тээшийн эзний өмнөөс тээвэрлэлтэд оролцож, тээвэрлэлтийн бичиг баримтад илгээгчээр заагдсан хувь хүн, хуулийн этгээдийг;

4.1.3.“**ачаан тээш**” гэж зорчигч болон шуудан тээшийн галт тэргээр тээвэрлэгдэж байгаа ачаа, эд хөрөнгийг;

4.1.4. “**ачаа хүлээн авагч**” гэж ачаа, ачаан тээш, тээшийг хүлээн авах эрхтэй, тээвэрлэлтийн бичиг баримтад хүлээн авагчаар заагдсан хувь хүн, хуулийн этгээдийг;

4.1.5.“**галт тэрэг**” гэж дэд бүтэц эзэмшигчийн тодорхойлсон замналаар явуулахаар найруулж холбосон, дохио бүхий нэг болон хэд хэдэн зүтгүүртэй бүлэг вагон, эсхүл вагонгүй зүтгүүр, өөрөө явагч хөдлөх бүрэлдэхүүнийг;

4.1.6.“**гол зам**” гэж зэргэлдээ өртөөг өөр хооронд нь холбосон хоорондын замын шууд үргэлжлэл (өртөөний хязгаарт орших)-ийг;

4.1.7. **”диспетчерийн удирдлага”** гэж тээвэрлэлтийн процессын ажилбаруудыг цаг тухайд нь шууд удирдах, хянах үйл ажиллагааг;

4.1.8. **”зорчигч”** гэж галт тэргээр зорчиж байгаа зорчих тасалбартай хувь хүнийг;

4.1.9. **”зураг төсөл”** гэж төмөр замын дэд бүтцийг төлөвлөх, барилгын ажил гүйцэтгэхэд шаардагдах загвар зураг, эх загвар зураг (эскиз), техник, эдийн засгийн үндэслэл, техникийн болон ажлын зураг, барилгын ажил гүйцэтгэх талбайн болон үйлдвэрлэлийн зохион байгуулалтын төсөл, инженер хайгуулын судалгаа, инженер геологи, геодезийн зураглал, инженерийн тооцоо, төмөр замын шугамын чигийн зураг, дагуу огтлолын зураг, дэвсгэр зураг, өртгийн төсөв зэрэг баримт бичгийн иж бүрдлийг;

4.1.10. **”зуучлагч”** гэж тээвэр зуучлалын гэрээний үндсэн дээр тээврийн хөлс төлөх үүрэгтэйгээр тээвэрлэлтийн бичиг баримтад заагдсан, ачааны тээвэрлэлт зохион байгуулах үйлчилгээ үзүүлж байгаа хуулийн этгээдийг;

4.1.11. **”нийтийн хэрэглээний зам”** гэж галт тэрэг хүлээж авах, явуулах, ялгах болон сэлгээний ажил гүйцэтгэх, ачаа, ачаан тээш хүлээн авах, олгох, зорчигчид болон нийтэд үйлчлэх зориулалттай өртөөний зам, түүнчлэн нийтэд үйлчлэх зориулалттай салбар замыг;

4.1.12. **”нийтийн хэрэглээний талбай”** гэж ачаа, ачаан тээшийг ачих буулгах, ялгах, хадгалахад ашиглаж байгаа, төмөр замын дэд бүтцийн эзэмшлийн, төмөр замын өртөөний нутаг дэвсгэр дэх нийтэд үйлчлэхээр тусгайлан гаргасан агуулах, талбайг;

4.1.13. **”нийтийн бус хэрэглээний зам”** гэж эзэмшигчийн өөрийн хэрэгцээг хангах, эсхүл гэрээний үндсэн дээр тодорхой хэрэглэгчид үйлчилгээ үзүүлэх, ачилт, буулгалт хийхэд зориулагдсан салбар замыг;

4.1.14. **”нийтийн бус хэрэглээний талбай”** гэж эзэмшигчийн өөрийн, эсхүл гэрээний үндсэн дээр тодорхой хэрэглэгчид үйлчилгээ үзүүлэх, ачих, буулгах төхөөрөмжөөр тоноглогдсон агуулах, талбайг;

4.1.15. **”овор”** гэж хөдөлгөөний ба хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, ачааг бүрэн бүтэн тээвэрлэх нөхцөлийг бүрдүүлэх, төмөр замын дэд бүтцийн иж бүрдэл болон хөдлөх бүрэлдэхүүн, ачааны байршил хоорондын зайн хязгаарыг;

4.1.16. **”өртөөний зам”** гэж өртөөний хязгаарт орших ялгах, ачих, буулгах, татах, холбох, тусгай болон технологийн зориулалтын төмөр зам (гол замаас бусад)-ыг;

4.1.17. **”тариф хэрэглэх дүрэм”** гэж вагон, чингэлэг ашиглах, зорчигч, ачаа, ачаан тээш, тээш тээвэрлэлтийн болон төмөр замын тээврийн бусад ажил үйлчилгээний тариф, хөлс, нэмэлт хураамжийн хэмжээ, тэдгээрийн бүтэц, тооцооллыг;

4.1.18. **”төмөр зам”** гэж төмөр замын дэд бүтэц, хөдлөх бүрэлдэхүүн, тээвэрлэлтийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах зориулалттай, зорчигч, ачаа тээвэрлэх тээврийн системийг;

4.1.19. **"төмөр замын байгууллага"** гэж төмөр замын дэд бүтэц эзэмшигч, тээвэрлэгчийг;

4.1.20. **"төмөр замын гарам"** гэж төмөр зам, авто болон явган хүний замтай нэг түвшинд огтлолцсон уулзварыг;

4.1.21. **"төмөр замын дэд бүтэц эзэмшигч"** гэж өмчлөл буюу эзэмшилдээ байгаа төмөр замын дэд бүтцийг ашиглах тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийг;

4.1.22. **"төмөр замын дэд бүтцийн нэвтрүүлэх чадвар"** гэж галт тэрэгний хөдөлгөөн зохион байгуулах арга, хөдлөх бүрэлдэхүүн, техник, технологийн боломжоос хамааруулан хоногт төмөр замын дэд бүтцийн хэсгээр өнгөрүүлж болох хос галт тэрэгний хамгийн их тоог;

4.1.23. **"төмөр замын дэд бүтэц дэх хөдөлгөөний зурмаг"** гэж хөдөлгөөний нэгдсэн зурмагт нийцүүлэн дэд бүтэц эзэмшигчийн баталсан тухайн дэд бүтэц дэх галт тэрэгний хөдөлгөөнийг зохицуулах төлөвлөлтийн баримт бичгийг;

4.1.24. **"төмөр замын өртөө"** гэж галт тэрэг хүлээж авах, явуулах, зөрүүлэх, зорчигчдод үйлчлэх, ачаа, ачаан тээш, тээш, шуудан илгээмжийг хүлээн авах, олгох, сэлгээний ажил хийх боломжтой, нэвтрүүлэх чадвар, хөдөлгөөн зохицуулалтыг хангах замтай төмөр замын дэд бүтцийн хэсгийг;

4.1.25. **"төмөр замын тээвэр"** гэж улсын болон хувь хүн, хуулийн этгээдийн тээврийн хэрэгцээг хангахад зориулагдсан төмөр замын дэд бүтэц, хөдлөх бүрэлдэхүүн, бусад эд хөрөнгийг өөртөө багтаасан тээврийн үйлдвэрлэл, технологийн иж бүрэн бүтцийг;

4.1.26. **"төмөр замын тээврийн норм, норматив, техникийн баримт бичиг"** гэж төмөр замын зураг төсөл, төслийн баримт бичиг боловсруулалт, төмөр замын дэд бүтцийн барилгын ажил, дэд бүтцийн ашиглалт, хөдлөх бүрэлдэхүүний үйлдвэрлэл, угсралт, засвар, төмөр замын тээвэрлэлт, хөдөлгөөн зохион байгуулалт, аюулгүй байдлын нөхцөл, шаардлагыг тодорхойлсон норм, норматив, дүрэм, журам, заавар, аргачлал, цомог, төсвийн үнэ бүрдэлтэй холбоотой баримт бичгийг;

4.1.27. **"төмөр замын тээврийн бүртгэл, мэдээллийн сан"** гэж төмөр замын салбарын үйл ажиллагаатай холбоотой дэд бүтэц, хөдлөх бүрэлдэхүүн, тээвэрлэлтийн болон үйлдвэрлэлийн технологи, ажилтны статистик мэдээллийн бүртгэлийг;

4.1.28. **"төмөр замын чиг"** гэж төмөр замын чиглэлийн дагуу барих төмөр замын техник, эдийн засгийн үндэслэлээр тогтоосон шугамыг;

4.1.29. **"төмөр замын чиглэл"** гэж төмөр замын эхлэх, дайран өнгөрөх, төгсөх цэгийг ерөнхийлөн заасан байршлыг;

4.1.30. **"төмөр замын хөдлөх бүрэлдэхүүн"** гэж тээвэрлэлтэд ашиглаж байгаа зүтгүүр, ачаа, зорчигчийн вагон, зорчигчийн өөрөө явагч галт тэрэг болон шуудан, тээшийн, зам хэмжигч, оношлогооны, хэмжлийн вагон, дрезин, цас цэвэрлэгч, зам засварын машин, төмөр замаар явагч кран зэрэг төмөр замаар явдаг тусгай зориулалтын техникийг;

4.1.31. **“тээш”** гэж зорчигчоос тээшийн вагонд тээвэрлүүлэхээр илгээж байгаа, зорчих тасалбарт заасан хүрэх өртөөнд хүргэх, түүний хувийн хэрэгцээний эд хөрөнгийг;

4.1.32. **“тээвэрлэлт”** гэж зорчигч, ачаа, ачаан тээш, тээш, шуудангийн илгээмжийг илгээх газраас хүрэх газарт шилжүүлэхийг;

4.1.33. **“тээвэрлэгч”** гэж зорчигч, ачаа, ачаан тээш, тээш, шуудангийн илгээмжийг тээвэрлэх тусгай зөвшөөрөлтэй, хөдлөх бүрэлдэхүүнийг өмчилж эзэмшиж байгаа тээвэрлэлтийн бичиг баримтад заасан этгээдийг;

4.1.34. **“тээвэрлэлтийн бичиг баримт”** гэж зорчих тасалбар, ачаа, ачаан тээш, тээшийн тасалбар, төмөр замын тээврийн падаан зэрэг тээвэрлэлтийн гэрээ байгуулах үед үйлдэж байгаа бичиг баримтыг;

4.1.35. **“тээвэрлэлтийн үйл ажиллагаа”** гэж төмөр замын тээвэрлэлтийн ажлыг бэлтгэх, гүйцэтгэх, дуусгах үед хийгдэх зохион байгуулалт, технологийн хувьд харилцан уялдаатай ажилбаруудын нэгдлийг;

4.1.36. **“тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч”** гэж тээврийн үйлчилгээг авч байгаа этгээд, тээвэрлэгч, дэд бүтэц эзэмшигч, хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч болон хөдлөх бүрэлдэхүүн, чингэлгийн операторыг;

4.1.37. **“хатуу тооцоот багаж, хэрэгсэл”** гэж ашиглах, хүлээлцэх ажиллагааг нь тусгай журмаар зохицуулдаг, хяналт, бүртгэлгүйгээр ашиглахад төмөр замын тээврийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөхүйц төмөр замын засвар, үйлчилгээний багаж, хэрэгслийг;

4.1.38. **“хөдлөх бүрэлдэхүүн, чингэлгийн оператор”** гэж төмөр замын хөдлөх бүрэлдэхүүн, чингэлгийг өмчилдөг, хууль буюу гэрээний дагуу эзэмшдэг, тээвэрлэгчтэй байгуулсан гэрээний үндсэн дээр хөдлөх бүрэлдэхүүн, чингэлгийг ашиглуулах үйлчилгээ үзүүлэхээр тээвэрлэлтэд оролцож байгаа тээвэрлэлтийн бичиг баримтад заасан иргэн, хуулийн этгээдийг;

4.2. Төмөр замын тээврийн нэр томъёоны тайлбарыг энэ хуульд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын төмөр замын нэр томъёоны стандартад заасныг баримтална.

5 дугаар зүйл. Төмөр замын тээврийн салбарт баримтлах зарчим

5.1. Төмөр замын сүлжээ байгуулахад дараах зарчмыг баримтална.

5.1.1. төмөр замын сүлжээг Монгол Улсын хөгжлийн бодлоготой уялдуулан хөгжүүлэх;

5.1.2. төмөр замын сүлжээг хөгжүүлэх, ашиглах удирдлага, зохион байгуулалтын нэгдмэл бүтэц, тогтолцоотой байх.

5.2. Төмөр замын тээвэрт дор дурдсан зарчмыг баримтална:

5.2.1. зурмагийн нэгдсэн зохицуулалттай байх;

5.2.2. нэгдмэл удирдлагатай, байнгын хяналттай байх;

5.2.3. хөдөлгөөний аюулгүй байдлыг хангасан байх;

5.2.4.хэрэглэгчийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн байх;

5.2.5.эдийн засгийн үр ашигтай байх.

6 дугаар зүйл.Төмөр замын тээврийн салбарын норм, норматив, техникийн баримт бичиг, норм, нормативын сан

6.1.Төмөр замын тээврийн салбар нь норм, норматив, техникийн баримт бичгийн нэгдсэн тогтолцоотой байна.

6.2.Төмөр замын тээврийн норм, норматив, техникийн баримт бичгийг хуулиар тусгайлан эрх олгогдсон төрийн захиргааны байгууллага батална.

6.3.Төмөр замын тээврийн салбарын хууль тогтоомж, техникийн зохицуулалт, норм, норматив, техникийн баримт бичиг, стандарт боловсруулах, судалгаа хийх, хэвлэж олшруулах, сурталчлах болон тэдгээрийг зохион байгуулахтай холбоотой үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилго бүхий “Төмөр замын тээврийн норм нормативын сан”-тай байна.

6.4.“Төмөр замын тээврийн норм, нормативын санг бүрдүүлэх, захиран зарцуулах, ашиглах, хяналт тавих, тайлагнах журам”-ыг Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

6.5.Төмөр замын тээврийн норм, нормативын сан дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

6.5.1.төмөр замын дэд бүтэц, салбар зам барих, засварлах, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийн ажлын төсөвт өртгөөс 0.18 хувиар авсан орлого;

6.5.2.төмөр замын тээврийн норм, норматив, техникийн баримт бичгийг худалдсаны орлого;

6.5.3.төмөр замын тээврийн норм, норматив, техникийн баримт бичгийг боловсронгуй болгох зорилгоор иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын орлого;

6.5.4.бусад орлого.

6.6.“Төмөр замын тээврийн норм, нормативын сан”-гийн хөрөнгийг энэ хуулийн 6.3-д зааснаас өөр зорилгоор зарцуулахыг хориглоно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН САЛБАР ДАХЬ ТӨРИЙН ЗОХИЦУУЛАЛТ

7 дугаар зүйл. Төмөр замын тээврийн талаарх Засгийн газрын бүрэн эрх бодлого

7.1.Төмөр замын тээврийн талаар төрөөс баримтлах бодлого батлах;

7.2.Төмөр замын тээврийн салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах;

7.3.Төмөр замын тээврийн салбарын төсөв, хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогыг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

7.4.Төмөр замын тээврийн норм, нормативын баримт бичгийн ерөнхий тогтолцоог батлах;

7.5.энэ хуульд заасан төмөр замын тээвэртэй холбоотой дүрэм, журам, техникийн зохицуулалтыг батлах.

7.6.хууль тогтоомжид заасан бусад.

8 дугаар зүйл. Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

8.1.Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

8.1.1.төмөр замын тээврийн талаарх хууль тогтоомжийг биелүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хангах;

8.1.2.төмөр замын тээврийн салбар дахь төрийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн төлөөллийг хууль, олон улсын гэрээнд заасны дагуу хэрэгжүүлэх;

8.1.3.төрийн захиалгаар хийгдэх тээвэрлэлттэй холбоотой үйл ажиллагаанд төрийн төлөөллийг хэрэгжүүлэх;

8.1.4.төмөр замын тээврийн салбарт Засгийн газраас хийсэн хөрөнгө оруулалт, гадаад орны зээл тусламжийн хөрөнгийн ашиглалт, зарцуулалтад хяналт тавих;

8.1.5.төмөр замын олон улсын хамтын ажиллагаанд Монгол Улсыг төлөөлөх;

8.1.6.төмөр замын тээврийн талаар төрөөс баримтлах бодлого боловсруулахад дор дурдсан зарчим баримтална:

8.1.6.1. бусад салбарын хөгжлийн бодлоготой уялдуулах;

8.1.6.2. төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангах;

8.1.6.3. хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчныг хамгаалах;

8.1.6.4. төмөр замын тээвэрт бизнесийг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг татах нөхцөлийг бүрдүүлэх;

8.1.6.5. олон улсын төмөр замын тээврийн зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх;

8.1.6.6. нийтийн хэрэгцээний төмөр замын дэд бүтэцэд хөрөнгийн хувьд нэгдмэл байх;

8.1.6.7. төмөр замын тээврийн салбарт импортыг орлох үйлдвэрлэлийг хөгжүүлэх;

8.1.6.8. ачаа тээвэрлэлтэд тээвэр, логистикийн системийг хөгжүүлэх.

8.1.7.төмөр замын тээврийн салбарын шинжлэх ухаан, техник технологийн бодлогыг боловсруулж батлах;

8.1.8.энэ хуульд заасан төмөр замын тээврийн дүрэм, журмыг батлах;

8.1.9.төмөр замын тээврийн салбарын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сангийн журам батлах;

8.1.10.хууль тогтоомжид заасан бүрэн эрх.

8.2.Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь дэргэдээ сургалт, судалгаа шинжилгээний байгууллагатай байж болно.

9 дүгээр зүйл.Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх

9.1.Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

9.1.1.төмөр замын тээврийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, биелэлтэд хяналт тавих;

9.1.2.хуулиар олгосон бүрэн эрхийнхээ хүрээнд дүрэм, журам баталж, хэрэгжилтэд хяналт тавих;

9.1.3.төмөр замын тээврийн салбарт шударга бус өрсөлдөөн үүсэхээс сэргийлэх зорилгоор тариф хэрэглэх дүрмийг хянаж, санал, дүгнэлт гаргах;

9.1.4.төмөр замын тээврийн аюулгүй байдал, үйлчилгээний чанар, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн төрийн хяналтыг хэрэгжүүлэх;

9.1.5.төмөр замын салбарын мэдээллийг цуглуулах, нэгтгэх, бүртгэх дүгнэлт гаргах, дүн шинжилгээ хийх;

9.1.6.төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрх олгосны дагуу төмөр замын олон улсын хамтын ажиллагаанд Монгол Улсыг төлөөлөх;

9.1.7.төмөр замын тээврийн салбарт мөрдөх улсын стандартыг боловсруулж, эрх бүхий байгууллагаар батлуулах;

9.1.8.төмөр замын хамтын ажиллагааны байгууллагын баталсан дүрэм, журмыг Монгол Улсын төмөр замын тээвэрт мөрдүүлэх ажлыг зохион байгуулах;

9.1.9.төмөр замын дэд бүтцийн болон тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээдийн харилцан мэдээлэл солилцох журмыг батлах;

9.1.10.хатуу тооцоот багаж, хэрэгслийн төрөл, үйлдвэрлэх, худалдах, ашиглах болон хүлээлцэх журмыг батлах;

9.1.11.хуульд заасан бусад бүрэн эрх.

9.2.Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дэргэд төр, хувийн хэвшлийн төлөөллөөс бүрдсэн зөвлөх үүрэг бүхий орон тооны бус зөвлөл ажиллаж болно.

10 дугаар зүйл.Төмөр замын тээврийн салбарын үйл ажиллагаатай холбоотой аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх

10.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

10.1.1.Хот, дүүргийн зорчигч тээвэрт метро, хөнгөн галт тэрэг болон тэдгээртэй адилтгах төмөр замын бусад хөдлөх бүрэлдэхүүнийг ашиглах үйл ажиллагааг зохион байгуулах;

10.1.2.төмөр замын тээврийн байгууллагатай хамтран зурвас газар, объектод нийгмийн хэв журам сахиулах ажлыг зохион байгуулах;

10.1.3.хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол ээлжээр ажилладаг галт тэрэгний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажилтныг цэргийн албанд татахаас бусад дайчилгаанд хамруулахгүй байх;

10.1.4.гамшгийн улмаас төмөр замын тээврийн тасралтгүй, хэвийн үйл ажиллагаанд учирсан хор уршгийг арилгахад шаардагдах байгалийн нөөц (түгээмэл тархацтай ашигт малтмал мод, ус зэрэг)-ийг хууль тогтоомжийн дагуу ашиглуулах;

10.1.5.гамшгийн хор уршгийг арилгах, аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан нутаг дэвсгэр дэх аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн эзэмшил, ашиглалтад байгаа тоног төхөөрөмжийг нөхөн олговортойгоор дайчлах, хүн хүчний туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулах;

10.1.6.энэ хуулийн 15.2-т заасан дэглэмийг төмөр замын тээврийн байгууллагатай хамтран мөрдүүлэх.

11 дүгээр зүйл.Төмөр замын тээвэр дэх төрийн захиргааны хяналт

11.1.Төмөр замын тээврийн салбарт төмөр замын тээврийн аюулгүй байдал, үйлчилгээний чанар, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйд тавих төрийн захиргааны хяналтыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий хяналтын нэгж байна.

11.2.Хяналтын нэгж нь улсын ахлах байцаагч, улсын байцаагчтай байна.

11.3.Төмөр замын тээврийн улсын ахлах байцаагч, улсын байцаагчийн эрхийг төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын санал болгосноор мэргэжлийн хяналтын байгууллагын улсын ерөнхий байцаагч олгоно.

11.4.Хяналтын нэгж нь төрийн захиргааны хяналтыг дараах чиглэлээр хэрэгжүүлнэ:

11.4.1.төмөр замын тээврийн тухай хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэх үндсэн дээр гаргасан бусад шийдвэрийн биелэлтэд хяналт тавих;

11.4.2.төмөр замын тээврийн салбарт мөрдөж буй дүрэм журам, холбогдох эрх зүйн актыг сайжруулах талаар санал гаргах;

11.4.3.төмөр замын дэд бүтэц, хөдлөх бүрэлдэхүүн, техник хэрэгсэл, байгууламж, төхөөрөмж, гарам, салбар зам, ажил, үйлчилгээ, технологи нь төмөр замын тээврийн болон хүрээлэн байгаа орчин, техникийн зохицуулалт, дүрэм, журам, стандартын шаардлагад нийцэж байгаа эсэхийг өмчийн хэлбэр, байршил харгалзахгүйгээр шалгах;

11.4.4.төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангах талаар тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогчид үүрэг, чиглэл өгч, биелэлтийг хангуулах;

11.4.5.төмөр замын тээврийн байгууллагад аюулгүй байдлын зөвлөмж өгөх;

11.4.6.төмөр замын дэд бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнийг ашиглалтад оруулах, ашиглалтаас хасах талаар мэргэжлийн дүгнэлт гаргах;

11.4.7.төмөр замын тээвэрт гарсан сүйрэл, осол, аюулгүй байдал алдагдсан үйл явдлын шалтгааныг судалж, давтагдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, судалгаа гаргах, баримт мэдээлэл хадгалах;

11.4.8.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

11.5.Төмөр замын тээврийн хяналтын улсын ахлах байцаагч, байцаагч нь үйл ажиллагаандаа Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, энэ хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм, журам, стандартыг баримтална.

11.6.Хяналтын нэгжийн улсын байцаагч нь албан үүргээ гүйцэтгэх үедээ галт тэргээр эрхийн үнэмлэхээр үнэгүй зорчино.

12 дугаар зүйл.Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв, түүний чиг үүрэг, бүрэн эрх

12.1.Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв (цаашид “хөдөлгөөн зохицуулалтын төв” гэх) нь төмөр замын дэд бүтэц хоорондын галт тэрэгний хөдөлгөөнийг нэгдсэн зохицуулалтаар хангах чиг үүрэгтэй.

12.2.Галт тэрэгний хөдөлгөөнийг нэгдсэн зохицуулалтаар хангах журмыг төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

12.3.Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын төв нь дараах бүрэн эрхтэй:

12.3.1.хөдөлгөөний нэгдсэн зурмагийг батлах;

12.3.2.хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилтын хүрээнд дэд бүтэц хоорондын галт тэрэгний хөдөлгөөнийг зохицуулах;

12.3.3.галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын оновчтой байдал, дэд бүтцийн тээх, нэвтрүүлэх чадвар, хөдлөх бүрэлдэхүүний ашиглалтад дүн шинжилгээ хийх, дүгнэлт гаргах;

12.3.4.галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн дэд бүтэц эзэмшигчийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

12.3.5.төмөр замын тээврийн хүртээмжтэй байдлыг хянах, тээвэрлэгч, хөдлөх бүрэлдэхүүн, чингэлгийн оператор, тээвэр зуучийн тэгш оролцоог хангуулах;

12.3.6.төмөр замын дэд бүтэц, хөдлөх бүрэлдэхүүн болон тээвэрлэлтийн статистикийн тайлан мэдээг төмөр замын байгууллагаас авч, нэгтгэх, дүн шинжилгээ хийх;

12.3.7.төмөр замын тээврийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн бүрдүүлж хөтлөх;

12.3.8.төмөр замын дэд бүтцүүдийн технологийн нэгдсэн горим, техникийн нормчлолын биелэлтийг хангуулах;

12.3.9.хилийн боомт, дэд бүтцүүдийн уулзварын өртөөнд галт тэрэг солилцох үйл явц, вагон урсгалын оновчтой зохион байгуулалт, галт тэрэг найруулах төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах;

12.3.10.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ЗОРИУЛАЛТТАЙ ГАЗАР

13 дугаар зүйл.Төмөр замын тээврийн зориулалттай газар

13.1.Төмөр замын дэд бүтэц барих, дэд бүтцийн үйлчилгээ үзүүлж, тээвэрлэлтийн үйл ажиллагаа явуулах болон төмөр замын бусад объект барьж ашиглах, төмөр замын байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад зориулагдсан газрыг төмөр замын тээврийн зориулалттай газар гэж үзнэ.

13.2.Төмөр замын тээврийн зориулалттай газарт төмөр замын зурвас газар, хамгаалалтын бүс байна.

13.3.Төмөр замын дэд бүтцийн зориулалттай газрыг Газрын тухай хууль, энэ хууль, холбогдох бусад хуульд заасны дагуу эзэмшиж ашиглана.

14 дүгээр зүйл.Төмөр замын зурвас газар, түүний өмчлөл, эзэмшил, ашиглалт

14.1.Төмөр замын тээврийн хэвийн, тасралтгүй үйл ажиллагааг хангах зориулалт бүхий, төмөр замын чигийн дагуух төмөр замын зам, түүний төхөөрөмж, байгууламж, өртөө, зөрлөг, эрчим хүч, усан хангамж, дохиолол, төвлөрүүлэлт, хориглол, холбоо, мэдээллийн болон төмөр замын тээврийн бусад объект байрласан болон байрлахаар зориулагдсан газрыг төмөр замын зурвас газар гэнэ.

14.2.Төмөр замын зурвас газар нь өмчийн төрөл, хэлбэрээс үл хамааран төрийн өмчид байна.

14.3.Төмөр замын зурвас газрыг төмөр замын дэд бүтэц эзэмшигч, ашиглагч нь тодорхой нөхцөл, хугацаа, төлбөртэй ашиглана.

14.4.Төмөр замын зурвас газарт мал бэлчээх, төмөр замын тээвэрт холбогдолгүй ажил гүйцэтгэх, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхийг хориглоно.

14.5.Төмөр замын зурвас газарт байрлаж байгаа харилцаа холбооны байгууламжийн үйл ажиллагааг тэдгээрийн эзэмшигч хариуцана. Харилцаа холбооны байгууламжийн байршлыг өөрчлөх, шинэчлэх үйл ажиллагаа нь төмөр замын дэд бүтэц, галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлэхээргүй байна.

14.6.Төмөр замын зурвас газар дахь мод, бут, өвс, ургамал нь тээврийн аюулгүй байдалд саад учруулахаар байвал төмөр замын тээврийн байгууллага тэдгээрийг шилжүүлэн суулгах, тайрах, огтлох, хадах, түймэр гаргахгүйгээр шатаах зэргээр аюулгүй байдлын нөхцөлийг хангана.

15 дугаар зүйл.Төмөр замын хамгаалалтын бүс

15.1.Төмөр замын дэд бүтцийг гаднын сөрөг хүчин зүйлээс үүдэлтэй болзошгүй эрсдэлээс сэргийлэх, төмөр замын сүйрэл, осол, гологдлоос хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчныг хамгаалах, төмөр замын аюулгүй байдлын орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор хамгаалалтын бүс тогтооно.

15.2.Төмөр замын зурвас газар, хамгаалалтын бүсийн дэглэмийг хот байгуулалт, төмөр замын тээврийн аюулгүй байдлын нөхцөл, шаардлагыг харгалзан Засгийн газар тогтооно.

15.3.Аюултай бодис үйлдвэрлэх, хадгалах, ачих, буулгах объектыг төмөр замын хамгаалалтын бүсэд барих, байгуулахыг хориглоно.

15.4.Хот, тосгоны хилийн заагаас гадна орших хамгаалалтын бүсэд төмөр замын байгууллагаас бусад байгууллага, аж ахуйн нэгж байрлах, иргэд оршин суухыг хориглоно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ТӨМӨР ЗАМЫН ДЭД БҮТЭЦ

16 дугаар зүйл.Төмөр замын дэд бүтэц

16.1.Төмөр замын дэд бүтэц нь дараах бүрдэл хэсэгтэй байна:

16.1.1.төмөр замын дээд байгууламж (зам төмөр, дэр, чигжээс, суман шилжүүлэг болон бусад дээд байгууламж), нэг болон өөр түвшний огтлолцол;

16.1.2.төмөр замын доод байгууламж (гүүр, хоолой, ус зайлуулах, чиглүүлэх төхөөрөмж, тогтоох хана, хамгаалалт хана болон бусад);

16.1.3.хашаа, хамгаалалтын байгууламж, ногоон байгууламж;

16.1.4.төмөр замын өртөө, хэсэглэх газар;

16.1.5.төмөр замын дохиолол, төвлөрүүлэлт, хориглолын байгууламж, сум дохионы харилцан хамаарлын болон диспетчерийн удирдлага зохицуулалтын систем зэрэг галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах байгууламжууд;

16.1.6.төмөр замын харилцаа холбооны сүлжээ;

16.1.7.агаарын болон газар доорх төмөр замын цахилгаан, ус хангамжийн шугам, контактны сүлжээ, трансформатор болон татах дэд станцууд;

16.1.8.төмөр замын дэд бүтцийн байгууламжийн ашиглалт, засвар, арчлалтын зориулалттай барилга байгууламж;

16.1.9.төмөр замын зурвас газар, зурвас газрын дагуух агаарын орон зай.

17 дугаар зүйл.Төмөр замын дэд бүтцийн төрөл

17.1.Төмөр замын дэд бүтэц нийтийн хэрэгцээний ба нийтийн бус хэрэгцээний төмөр замын дэд бүтэц гэсэн төрөлтэй байна.

17.2.Нийтийн хэрэгцээний төмөр замын дэд бүтцэд Монгол Улсын нийслэл, аймгийн төв, улсын зэрэглэлтэй хот, аж үйлдвэрийн төвүүд, хөрш орнуудын хилийн боомтуудыг холбосон, түүнчлэн улс, олон улс, орон нутгийн зорчигч, ачаа тээврийн үйлчилгээг нийтэд үзүүлэх төмөр замын дэд бүтэц орно.

17.3.Нийтийн бус хэрэгцээний төмөр замын дэд бүтцэд нэг эсхүл хэсэг хэрэглэгчид гэрээний үндсэн дээр тодорхой чиглэлд зорчигч болон ачаа тээврийн дагнасан үйлчилгээг үзүүлэх зориулалтын дэд бүтэц орно.

17.4.Нийтийн болон нийтийн бус хэрэгцээний төмөр замын дэд бүтэц нь үл хөдлөх хөрөнгийн улсын бүртгэлд бүртгэгдсэн байна.

17.5.Нийтийн хэрэгцээний төмөр замын дэд бүтцийг чиг үүрэг, техникийн хүчин чадалд нь тулгуурлан дараах байдлаар ангилна:

17.5.1.стратегийн ач холбогдолтой нийтийн хэрэгцээний төмөр замын дэд бүтэц;

17.5.2.бус нутгийн ач холбогдолтой нийтийн хэрэгцээний төмөр замын дэд бүтэц.

17.6.Стратегийн болон бус нутгийн ач холбогдолтой нийтийн хэрэгцээний төмөр замын дэд бүтцийн ангиллыг Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

18 дугаар зүйл.Төмөр замын дэд бүтцийн өмчлөл, эзэмшил

18.1.Нийтийн хэрэгцээний төмөр замын дэд бүтэц төрийн өмчид байх бөгөөд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд эзэмшинэ.

18.2.Нийтийн бус хэрэгцээний төмөр замын дэд бүтэц төрийн болон хувийн өмчийн аль ч хэлбэрийн байж болно

18.3.Төмөр замын дэд бүтцийг концессын барих-ашиглах-шилжүүлэх төрлөөр барьж байгуулсан бол уг гэрээний хугацаанд концесс эзэмшигч нь тухайн дэд бүтцийн эзэмшигч байна.

19 дүгээр зүйл.Төмөр замын сүлжээ

19.1.Төмөр замын тээврийн үйлчилгээ үзүүлэхээр харилцан холбогдож, ачаа, зорчигч тээвэрлэлтийн үйлчилгээг нэгдсэн зурмагаар үзүүлж байгаа төмөр замын дэд бүтэц бүхий төлөвлөлт, техник, эдийн засаг, удирдлага, зохицуулалтын нэгдмэл үйл ажиллагааг төмөр замын сүлжээ гэж үзнэ.

19.2.Төмөр замын сүлжээ байгуулахад дараах хүчин зүйлийг харгалзана:

19.2.1.ашигт малтмалын стратегийн орд газруудын байршил, нөөц, ашиглах боломж;

19.2.2.газрын гадаргын хэв шинж, газар зүйн байршил, бартаажилт, уул, даваа, ус, гол, горхи, элс, инженер-геологийн нөхцөл;

19.2.3.аялал жуулчлалыг хөгжүүлэх нөхцөл, нөөц аялал жуулчлал, амралт, сувилалын гол бүс нутгуудын байршил;

19.2.4.байгаль орчныг хамгаалах нийтлэг зарчим, тусгай хамгаалалттай газар нутгийн байршил, ашиглалтын горим;

19.2.5.хүн амын суурьшил, хот суурины байршил, ирээдүйн хөгжлийн төлөв;

19.2.6.эрчим хүч, холбоожуулалтын нэгдсэн систем, тэдгээрийн хөгжлийн хэтийн төлөв;

19.2.7.олон улсын болон хил орчмын бүс нутгийн хамтын ажиллагааны хэтийн төлөв.

19.2.8.шаардлагатай бусад.

20 дугаар зүйл.Төмөр замын дэд бүтцийн үйлчилгээ

20.1.Төмөр замын дэд бүтэц өмчлөгч, эзэмшигч нь өмчийн хэлбэрээс үл хамааран тээвэрлэгч, хөдлөх бүрэлдэхүүн, чингэлгийн оператор зэрэг этгээдэд гэрээний үндсэн дээр дэд бүтцийн үйлчилгээ үзүүлнэ.

20.2.Төмөр замын дэд бүтцийн үйлчилгээ нь үндсэн болон нэмэлт үйлчилгээнээс бүрдэнэ.

20.3.Төмөр замын дэд бүтцийн үндсэн үйлчилгээнд дараах ажил, үйлчилгээ орно:

20.3.1.төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас тогтоосон төмөр замын дэд бүтцийн нэвтрүүлэх чадварыг ашиглуулах;

20.3.2.галт тэрэгний хөдөлгөөнд зам, суман шилжүүлэг ашиглуулах;

20.3.3.галт тэрэгний хөдөлгөөнийг нэгдсэн удирдлагаар хангах үйлчилгээ (харилцаа холбоо, дохиоллын системийг ашиглан хөдөлгөөнийг зохион байгуулах диспетчерийн үйлчилгээ), галт тэрэгний хөдөлгөөнтэй холбоотой мэдээлэл солилцох, дамжуулах үйлчилгээ;

20.3.4.төмөр замын дэд бүтцийн нэвтрүүлэх чадварыг ашиглуулах явцад тээвэрлэлтийн үйлчилгээтэй холбоотой мэдээллээр тээвэрлэгчийг хангах.

20.4.Төмөр замын дэд бүтцийн нэмэлт үйлчилгээнд дараах ажил, үйлчилгээ орно:

20.4.1.цахилгаан галт тэргийг гүйдлээр хангах үйлчилгээ;

20.4.2.зорчигчийн галт тэргийг халаах үйлчилгээ;

20.4.3.түлш шатахуун, тоног төхөөрөмжөөр хангах, сэлгээний ажил хийх, харуул хамгаалалтын үйлчилгээ;

20.4.4.аюултай ачааны тээвэрлэлт болон хүнд жинтэй, хэтрүү овортой зэрэг онцгой нөхцөл шаардсан галт тэргэнд хяналт тавихтай холбоотой үйлчилгээ;

20.4.5.хөдлөх бүрэлдэхүүний техникийн үзлэг (магадалгаа);

20.4.6.харилцаа холбооны үйлчилгээ;

20.4.7.нэмэлт мэдээллээр хангах үйлчилгээ;

20.4.8.бусад үйлчилгээ.

20.5.Тээвэрлэлтийн эрэлт хэрэгцээ дэд бүтцийн нэвтрүүлэх чадвараас давсан тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу уралдаант шалгаруулалт явуулах замаар тээвэрлэгчийг сонгоно.

20.6.Төмөр замын дэд бүтцийг ашиглуулахтай холбоотой харилцааг Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмаар зохицуулна. Журамд дараах зүйлийг тусгана:

20.6.1.төмөр замын дэд бүтцэд тээвэрлэгч нэвтрэх зарчим, дараалал;

20.6.2.хязгаарлагдмал нэвтрүүлэх чадвар бүхий төмөр замын дэд бүтцэд тээвэрлэгч нэвтрэх зохицуулалт;

20.6.3.төмөр замын дэд бүтцийн нэвтрүүлэх чадварын хүрэлцээ, техник, технологийн боломж;

20.6.4.төмөр замын дэд бүтцийн үйлчилгээтэй холбоотой мэдээлэл солилцох, дамжуулах;

20.6.5.төмөр замын дэд бүтцийн үйлчилгээтэй холбоотой бусад зохицуулалт.

20.7.Төмөр замын дэд бүтэц эзэмшигч нь дэд бүтцийн үйлчилгээг тэгш эрхийн зарчмыг баримтлан, тусгай зөвшөөрлийн үндсэн дээр үзүүлнэ.

21 дүгээр зүйл.Төмөр замын дэд бүтэц ашиглуулахад тавигдах шаардлага

21.1.Төмөр замын дэд бүтэц ашиглуулах болон тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг нэг хуулийн этгээдэд давхардуулан олгохгүй.

21.2.Төмөр замын дэд бүтэц эзэмшигч нь тээвэрлэгч, тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогчийг ялгаварлан гадуурхах, давуу байдал олгох замаар өрсөлдөөнийг хязгаарлах, тэгш бус хандах, үйл ажиллагаанд нь саад учруулахыг хориглоно.

21.3.Төмөр замын дэд бүтэц эзэмшигч нь тээвэрлэгч, тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогчтой дэд бүтэц ашиглуулах гэрээ байгуулахаас үндэслэлгүйгээр татгалзахыг хориглоно.

21.4.Төмөр замын дэд бүтэц нь тухайн дэд бүтцийн өргөтгөл, шинэчлэн сайжруулалтын суурь судалгаа бүхий хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй байна.

21.5.Төмөр замын дэд бүтэц ашиглуулах үйл ажиллагаа нь төмөр замын тээврийн аюулгүй байдал, технологи, стандартын шаардлагад нийцсэн байна.

22 дугаар зүйл. Төмөр замын дэд бүтэц эзэмшигчийн эрх, үүрэг

22.1.Төмөр замын дэд бүтэц эзэмшигч дараах эрхтэй:

22.1.1.төмөр замын дэд бүтцийг гэрээний үндсэн дээр тээвэрлэгч, тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогчид ашиглуулах;

22.1.2.төмөр замын дэд бүтэц ашиглуулсны төлбөр, засвар, үйлчилгээний хөлс авах;

22.1.3.тээвэрлэгчийн тээвэрлэлтийн ажлын технологи, хөдлөх бүрэлдэхүүний техникийн үзүүлэлт, хүчин чадал нь төмөр замын дэд бүтцийн нэвтрүүлэх чадварыг бүрэн ашиглахад сөргөөр нөлөөлөхүйц байвал тээвэрлэгчээс татгалзах;

22.1.4.тээвэрлэлтэд оролцож байгаа хөдлөх бүрэлдэхүүний засвар хоорондын хугацаа, техникийн байдалд хяналт тавьж, зөрчлийг арилгуулахыг шаардах, шаардлагатай тохиолдолд дэд бүтэц ашиглуулахаас татгалзах;

22.1.5.аюултай ачааны тээвэрлэлт болон хүнд жинтэй, хэтрүү овортой зэрэг онцгой нөхцөл шаардсан галт тэргэнд тээвэрлэгчийн зүгээс хяналт тавьж тээвэрлэлтийн явцад аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авахыг шаардах;

22.1.6.хууль тогтоомжид заасан бусад эрх.

22.2.Төмөр замын дэд бүтэц эзэмшигч нь дараах үүрэгтэй:

22.2.1.төмөр замын дэд бүтэц ашиглуулах үйлчилгээний тариф хэрэглэх дүрмийг Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас баталсан аргачлалын дагуу энэ хууль болон Өрсөлдөөний тухай хуульд нийцүүлэн тогтоох;

22.2.2.төмөр замын тээврийн тухай хууль тогтоомж, техникийн зохицуулалт, дүрэм, журам, стандарт, холбогдох бусад эрх зүйн актыг дагаж мөрдөх;

22.2.3.хөдөлгөөний нэгдсэн зурмаг болон дэд бүтэц дэх хөдөлгөөний зурмагийг биелүүлж, өөрийн дэд бүтцийн хүрээнд галт тэрэгний хөдөлгөөнийг зохион байгуулах;

22.2.4.холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, техникийн зохицуулалт, стандартын шаардлагад нийцээгүй хөдлөх бүрэлдэхүүнийг өөрийн дэд бүтцэд нэвтрүүлэхгүй байх;

22.2.5.өөрийн дэд бүтэцтэй холбогдсон төмөр замын дэд бүтэц, салбар зам эзэмшигчтэй гэрээ байгуулж, галт тэрэгний хөдөлгөөнийг зохион байгуулах;

22.2.6.Төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмын дагуу өөрийн дэд бүтэц дэх хөдөлгөөний зурмагийг боловсруулж, батлах;

22.2.7.галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зурмагт санал өгөх;

22.2.8.эзэмшиж, ашиглаж байгаа хатуу тооцоот багаж хэрэгслийг Тагнуулын ерөнхий газарт бүртгүүлэх;

22.2.9.тусгай зөвшөөрөл, аюулгүй байдлын гэрчилгээтэй байх;

22.2.10.шаардлагатай мэргэжлийн ажилтантай байх;

22.2.11.эзэмшиж байгаа төмөр замын дэд бүтцийн тасралтгүй, хэвийн, аюулгүй ажиллагааг хангах;

22.2.12.тогтоосон журам, технологийн дагуу дэд бүтцийг засварлах, арчлах;

22.2.13.дүрэм, журмын дагуу эрх бүхий байгууллагад холбогдох мэдээ, тайлан гаргах;

22.2.14.хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

23 дугаар зүйл.Төмөр замын өртөө, зорчигчид үйлчлэх цогцолбор, ачих, буулгах терминал, жинлэх төхөөрөмж

23.1.Тээвэрлэгч нь зорчигчид үйлчлэх, ачаа, ачаан тээш, тээш, шуудангийн илгээмжийг хүлээж авах, олгох, галт тэрэг хүлээж авах, явуулах, зөрүүлэх, гүйцэж түрүүлэх үйл ажиллагааг явуулах зориулалт бүхий нээлттэй өртөө, хэсэглэх газрын хооронд тээвэрлэлт хийнэ.

23.2.Төмөр замын өртөөг ажлын зориулалт, шинж чанараас нь хамааруулан зорчигчийн, ачааны, ялгах, хэсгийн, завсрын гэж ангилна.

23.3.Төмөр замын өртөө нь галт тэрэг найруулах, сэлгээ хийх, хөдлөх бүрэлдэхүүнд үзлэг, засвар хийх зориулалт бүхий замтай байна.

23.4.Төмөр замын өртөөнд тээврийн үйл ажиллагааны технологид нийцүүлэн хил, гааль, мал эмнэлэг, ургамал хорио цээрийн зэрэг хяналтын байгууллага үйл ажиллагаа явуулна.

23.5.Өртөө нь зорчигч, ачаа, ачаан тээш, тээш, шуудан илгээмжийг тээвэрлэх үйлчилгээг хэрэглэгч тэгш, хүртээмжтэйгээр хүртэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

23.6.Зорчигчийн өртөө нь зорчигчид үйлчлэх цогцолбортой байна.

23.7.Зорчигчид үйлчлэх цогцолбор нь тасалбар түгээвэр, хүлээлгийн танхим, ариун цэврийн (хөгжлийн бэрхшээлтэй болон групп тогтоолгосон иргэдэд зориулсан тусгай тоног, төхөөрөмж) болон эх, хүүхдийн өрөөтэй, эрүүл мэнд, нийтийн дэг журмыг сахиулах зэрэг үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

23.8. Зорчигчид үйлчлэх цогцолборыг тээвэрлэгч, тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч гэрээний үндсэн дээр ашиглана.

23.9.Төмөр замын зорчигчид үйлчлэх цогцолбор нь галт тэрэгний цагийн хуваарь, тээвэрлэлтийн тариф, үйлчилгээний цагийн хуваарь, иргэдэд үзүүлэх үйлчилгээний газруудын байршил зэрэг мэдээллийг нээлттэй байршуулсан байна.

23.10.Энэ хуулийн 23.9-д заасан мэдээллийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулалтын бичвэр, дохио, цахим хэрэгслийг ашиглан хүргэх боломжийг бүрдүүлсэн байна.

23.11.Зорчигчдын тавцан, шилжих тавцангийн орц, гарц нь хөгжлийн бэрхшээлтэй, хязгаарлагдмал хөдөлгөөнтэй иргэд хүртээмжтэй ашиглах боломжийг бүрдүүлсэн тусгай цахилгаан болон явган шатаар тоноглогдсон байна.

23.12.Төмөр замын дэд бүтэц эзэмшигч нь төмөр замын зорчигчид үйлчлэх цогцолборын орчны тохижилт, арчлалт, засвар, үйлчилгээг хариуцна.

23.13.Төмөр замын өртөөг нээх, хаахтай холбогдсон харилцааг Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмаар зохицуулна.

23.14.Нийтийн болон нийтийн бус хэрэглээний зам, талбай нь ачааны бүрэн бүтэн байдлыг хангаж, вагон, чингэлгийг тасралтгүй, аюулгүй ачих, буулгах шаардлагыг хангасан байгууламж, төхөөрөмжөөр тоноглогдсон, хүрээлэн байгаа орчны аюулгүй байдлын шаардлагад нийцсэн байна.

23.15.Энэ хуулийн 23.14-т заасан шаардлагыг хангахтай холбоотой зардлыг зам, талбай эзэмшигч хариуцна.

23.16.Их хэмжээгээр ачаа ачих, буулгах зориулалтын нийтийн болон нийтийн бус хэрэглээний зам, талбай нь тусгай зориулалтын байгууламж (эстакад, тусгай зориулалтын талбай, агуулах, цэвэрлэх, халдваргүйжүүлэх, мал, амьтан услах, төхөөрөмж)-тай байна.

23.17.Нийтийн бус хэрэглээний ачих, буулгах талбай нь ачилт, буулгалтын ажлыг тогтоосон хугацаанд гүйцэтгэх, вагон, чингэлгийг цэвэрлэх, бүрэн бүтэн байдлыг хангах, хөлдөх ачааг буулгах зориулалтын тоног төхөөрөмжтэй байна.

23.18.Нийтийн болон нийтийн бус хэрэглээний зам, талбай нь ачаа, вагон, чингэлэг жинлэх төхөөрөмжөөр тоноглогдсон байна.

24 дүгээр зүйл.Төмөр замын дэд бүтцийг өөр тээврийн дэд бүтэц, байгууламжтай огтлолцуулах

24.1.Төмөр замын дэд бүтэц нь өөр төмөр замын дэд бүтэц, авто замтай ижил бус түвшинд огтлолцсон байна.

24.2.Төмөр замын дэд бүтэц нь авто замтай огтлолцох тохиолдолд төмөр замын дэд бүтэц давуу эрхтэй бөгөөд түүний чигийн дагуу өндөржилтийг өөрчлөхгүй байх зарчим баримтална.

24.3.Төмөр замын дэд бүтэц авто замтай огтлолцох байршлыг төмөр замын болон барилгын холбогдох норм дүрмээр тодорхойлно.

24.4.Төмөр замын гармын байршлыг тогтоохдоо нутгийн захиргааны байгууллага, төмөр замын дэд бүтэц эзэмшигч, төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөнө.

24.5.Төмөр замын дэд бүтцийг бусад төмөр замын дэд бүтэц болон авто замтай ижил бус түвшинд огтлолцуулах асуудлыг хөдөлгөөний аюулгүй байдал, гармаар нэвтрэх явган зорчигч, авто замын хөдөлгөөний нягтралыг харгалзан Зам, тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага шийдвэрлэнэ.

24.6.Гармыг нээх, хаах, ашиглах, хамгаалалтын дохио тэмдэг, төхөөрөмж суурилуулах, тоноглох, засварлах, арчлахтай холбоотой харилцааг Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, цагдаагийн байгууллагатай хамтран баталсан журмаар зохицуулна.

24.7.Төмөр замын гармын хэвийн ажиллагаа, ашиглалт, үйлчилгээ, аюулгүй байдлыг дэд бүтэц, нийтийн болон нийтийн бус хэрэглээний талбай, салбар зам эзэмшигч хариуцна.

24.8.Гинжит машин механизм, овортой ачаа бүхий авто тээврийн хэрэгслийг төмөр замын гармаар өнгөрүүлэхдээ тухайн гармыг хариуцсан дэд бүтэц эзэмшигчийн зөвшөөрлөөр, түүний томилсон ажилтны хяналт дор гүйцэтгэнэ.

24.9.Төмөр замын дэд бүтцийг авто замтай ижил бус түвшинд огтлолцуулах зардлыг шинээр буюу сүүлд зам тавьж байгаа этгээд хариуцна.

24.10.Эрх бүхий төрийн захиргааны байгууллагаас баталсан дүрэм, журам, стандарт, норм нормативаар төмөр замын дэд бүтцийг бусад байгууламжтай огтлолцуулах дор дурдсан шаардлагыг тогтооно:

24.10.1.нийтийн хэрэгцээний төмөр замын дэд бүтэц хүртэлх хамгийн бага зай;

24.10.2.хоолой (газрын тос, хий), цахилгаан, дулаан, холбооны шугам бусад байгууламжтай огтлолцсон болон ойртсон цэг;

24.10.3.огтлолцох байршилд объект барих, засварлах, арчлах норм.

24.11.Нийтийн хэрэгцээний төмөр замын дэд бүтэцтэй огтлолцож байгаа, эсхүл түүнд ойрхон оршиж байгаа хий, газрын тос дамжуулах хоолой, цахилгааны болон дулааны зэрэг шугам сүлжээ, бусад төхөөрөмж байгууламжийг барих, ашиглах үед тогтоосон норм, дүрэм, журам, стандартыг мөрдөх үүргийг эзэмшигч нь хүлээнэ.

25 дугаар зүйл.Төмөр замын дэд бүтцийн зураг төсөл

25.1.Төмөр замын дэд бүтцийг энэ хууль болон холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд нийцүүлэн, тусгай зөвшөөрлийн үндсэн дээр зураг төслийн дагуу барьж байгуулна.

25.2.Төмөр замын дэд бүтцийн зураг төслийг боловсруулах үйл явц нь дараах 3 үе шаттай байна:

25.2.1.төмөр замын техник, эдийн засгийн урьдчилсан үндэслэл;

25.2.2.төмөр замын техник эдийн засгийн үндэслэл;

25.2.3.ажлын зураг.

25.3.Салбар замын зураг төсөл нь ажлын зураг гэсэн нэг үе шаттай байна.

25.4.Төмөр замын дэд бүтцийн зураг төсөл Монгол Улсын хууль тогтоомж, дүрэм журам, стандартын шаардлагыг хангасан байна.

25.5.Төмөр замын төсөл хэрэгжүүлэх, зураг төсөл боловсруулах, магадлал хийхтэй холбоотой харилцааг Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмаар зохицуулна.

25.6.Тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллага төмөр замын зураг төслийг боловсруулж, эрх бүхий этгээд түүнд магадлал хийж, баталгаажуулна.

25.7.Төмөр замын дэд бүтцийн зураг төслийн магадлалыг ажлын 30 өдөрт багтаан хийнэ.

25.8.Эрх бүхий гадаад улсын хуулийн этгээдийн боловсруулсан төмөр замын дэд бүтцийн зураг төслийн баримт бичгийг Монгол Улсын эрх бүхий хуулийн этгээд хамтран баталгаажуулсан байх бөгөөд зураг төслийн баримт бичиг нь англи, монгол хэлээр үйлдэгдсэн байна.

25.9.Эрх бүхий гадаад улсын хуулийн этгээдийн боловсруулсан төмөр замын дэд бүтцийн зураг төслийг баталгаажуулахад тавих шаардлагыг энэ хуулийн 25.5-д заасан журамд тусгана.

25.10.Төмөр замын дэд бүтцийн барилгын ажлын явцад төмөр замын дэд бүтцэд хийц, бүтээцийн шинжтэй өөрчлөлт оруулсан бол тухайн өөрчлөлтийг тусгаж боловсруулсан зураг төсөлд дахин магадлал хийлгэнэ.

25.11.Магадлалын дүгнэлт нь татгалзсан, зөвшөөрсөн гэсэн хэлбэртэй байна.

25.12.Магадлалын татгалзсан дүгнэлт төмөр замын дэд бүтцийн барилгын ажлын зөвшөөрөл олгохоос татгалзах үндэслэл болно.

25.13.Энэ хуулийн 25.4-д заасан шаардлагыг зөрчсөн нь магадлалын татгалзсан дүгнэлт гаргах үндэслэл болно.

26 дугаар зүйл. Төмөр замын дэд бүтцийн барилгын ажил

26.1.Төмөр замын дэд бүтцийн барилгын ажлыг тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд гэрээний үндсэн дээр Монгол Улсын хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын дагуу гүйцэтгэнэ.

26.2.Төмөр замын дэд бүтцийн барилгын ажил гүйцэтгэгч нь гүйцэтгэлийн зураг төслийг эрх бүхий байгууллагаар гүйцэтгүүлж, баталгаажуулсан байна.

26.3.Төмөр замын дэд бүтцийн барилгын ажлын техник, технологийн хяналтыг эрх бүхий мэргэжлийн байгууллага гэрээний үндсэн дээр хэрэгжүүлнэ.

26.4.Төмөр замын дэд бүтцийн барилгын ажлын техник, технологийн хяналт хэрэгжүүлэх журмыг Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

26.5.Техник, технологийн хяналтын зөвлөх үйлчилгээний болон захиалагчийн хяналтын зардлыг тухайн төмөр замын дэд бүтцийн төсөвт өртөгт тусгана.

27 дугаар зүйл.Төмөр замын дэд бүтцийг ашиглалтад хүлээн авах, нийтэд зарлах

27.1.Төмөр замын дэд бүтцийг ашиглалтад хүлээн авах үйл ажиллагааг Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага зохион байгуулна.

27.2.Төмөр замын дэд бүтцийг байнгын ашиглалтад оруулахдаа “Төмөр замын дэд бүтцийн барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах дүрэм”-ийг баримтална. Энэхүү дүрмийг Засгийн газар батална.

27.3.Ашиглалтад хүлээн авах төмөр замын дэд бүтэц нь Монгол улсын хууль тогтоомж, дүрэм журам, стандарт, норм нормативын шаардлагыг бүрэн хангасан байна.

27.4.Төмөр замын дэд бүтцийн нэгдмэл бус бүрдэл хэсгийг хэсэгчлэн хүлээн авч, байнгын ашиглалтад оруулж болно.

27.5.Төмөр замын дэд бүтцийн барилга угсралтын ажил дууссаны дараа захиалагч нь барилга угсралтын ажил дууссан тухай гүйцэтгэгчийн албан ёсны мэдэгдлийн дагуу дараах үүрэг бүхий урьдчилсан комиссыг томилон ажиллуулна.

27.5.1.тухайн төмөр замын дэд бүтэц батлагдсан зураг төсөл болон түүнд оруулсан өөрчлөлтийн дагуу баригдсан, суурилуулагдсан эсэхийг шалгах;

27.5.2.гүйцэтгэлийн зураг төсөл хийгдсэн эсэхийг шалгах;

27.5.3.төмөр замын дэд бүтэц, түүний бүрдлийг шалгаж туршин акт, баримт, тайлан бүрдүүлж дүгнэлт гаргах.

27.6.Урьдчилсан комиссын шийдвэрийг үндэслэн захиалагч нь энэ хуулийн 27.1-д заасан эрх бүхий байгууллагад төмөр замын дэд бүтцийг ашиглалтад оруулах хүсэлтийг дараах баримт бичгийн хамт ирүүлнэ:

27.6.1.төмөр замын дэд бүтцийн барилгын үе шатны ажлын гүйцэтгэлийн тайлан;

27.6.2.барилгын ил, далд ажлын акт;

27.6.3.зураг төсөл зохиогчийн хяналтын нэгдсэн дүгнэлт;

27.6.4.захиалагчийн техникийн хяналтын нэгдсэн дүгнэлт;

27.6.5.төмөр замын дэд бүтцийн инженерийн шугам сүлжээний холболтыг техникийн нөхцөлийн дагуу гүйцэтгэснийг баталгаажуулсан тэмдэглэл, холбогдох мэдээлэл;

27.6.6.төмөр замын дэд бүтцийн өөрчлөлтийн зураг төсөл;

27.6.7.төмөр замын дэд бүтцийн гүйцэтгэлийн зураг.

27.6.8.энэ хуулийн 16.1-д заасан төмөр замын дэд бүтцийн бүрдэл хэсгийг угсарсан акт, туршилтын дүгнэлт.

27.7.Энэ хуулийн 27.1-д заасан эрх бүхий байгууллага төмөр замын дэд бүтцийг ашиглалтад оруулах хүсэлт, энэ хуулийн 27.6-д заасан баримт бичгийг хянаж, ажлын 15 өдрийн дотор багтаан комисс томилно.

27.8.Төмөр замын дэд бүтцийг дараах тохиолдолд ашиглалтад оруулахаас татгалзана:

27.8.1.энэ хуулийн 27.6-д заасан баримт бичгийг бүрдүүлээгүй;

27.8.2.энэ хуулийн 35 дугаар зүйлд заасан тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг зөрчсөн.

27.9.Энэ хуулийн 27.6-д заасан баримт бичгийн үнэн зөвийг захиалагч хариуцна.

27.10.Төмөр замын дэд бүтэц, түүний бүрдэл хэсгийг энэ хуульд заасны дагуу хүлээн авсны дараа байнгын ашиглалтад нээж олон улсад болон орон нутагт зарлахтай холбоотой харилцааг олон улсын төмөр замын хамтын ажиллагааны байгууллагын гэрээ, хэлэлцээр, дүрэм, журамд нийцүүлэн Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмаар зохицуулна.

28 дугаар зүйл.Төмөр замын дэд бүтцийн хувийн хэрэг

28.1.Төмөр замын дэд бүтэц нь төмөр замын дэд бүтцийн зураг төсөл, ил, далд ажлын акт, холбогдох шугам, сүлжээний гүйцэтгэлийн зураг, дэд бүтэц барих ажлын явц, чанарт холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас гаргасан дүгнэлт, ашиглалтад хүлээлгэн өгсөн баримт бичгээс бүрдсэн хувийн хэрэгтэй байна. Хувийн хэргийг төмөр замын дэд бүтцийг өмчлөгч, эзэмшигч хадгална.

28.2.Төмөр замын дэд бүтцийн хувийн хэрэг хөтлөх, дэд бүтцийг салбарын мэдээллийн санд бүртгэхтэй холбоотой харилцааг Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмаар зохицуулна.

29 дүгээр зүйл.Төмөр замын дэд бүтцийн санхүүжилт

29.1.Төмөр замын дэд бүтэц шинээр барих, шинэчлэн сайжруулах, түүнд засвар үйлчилгээ хийх ажлыг эзэмшигчийн, улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө, хуулиар хориглоогүй бусад эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

29.2.Төмөр замын дэд бүтцийн төсвийн тооцоо хийх, төлөвлөх, магадлахад дараах зарчмыг баримтална.

29.2.1.магадлагдсан зураг төсөлд үндэслэсэн байх;

29.2.2.төмөр замын дэд бүтцийн чиглэл, замнал, байгаль, цаг уурын нөхцөл, зурвас газартай холбоотой асуудлыг тусгасан байх;

29.2.3.төмөр замын дэд бүтцийн үнэ бүрдэл, төсвийн норм, нормативын баримт бичиг, дүрэм, заавар, аргачлалыг удирдлага болгосон байх;

29.2.4.хараат бус байх.

29.3.Улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх төмөр замын дэд бүтцийн төсвийн тооцоог эрх бүхий байгууллагаас зэрэг авсан мэргэшлийн зэрэгтэй төсөвчнөөр хийлгэсэн байна.

29.4.Улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх төмөр замын дэд бүтцийн материалын үнэ болон ханшны өөрчлөлт, бусад хүчин зүйлээс хамааран төмөр замын дэд бүтцийн төсвийн тооцоонд өөрчлөлт оруулах тохиолдолд эдийн засаг, санхүүгийн болон төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран үндэслэл, тооцоог хянаж, санхүүжүүлэх асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлэнэ.

29.5.Улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлж байгаа төмөр замын дэд бүтцийг холбогдох норм, нормативын баримт бичгийн шаардлагын дагуу гүйцэтгэсэн, зохих журмын дагуу магадлагдсан бол төмөр замын дэд бүтцийн барилгын ажлын гүйцэтгэлийн санхүүжилтийг үндэслэлгүйгээр саатуулахыг хориглоно.

29.6.Төмөр замын дэд бүтцийн үнэ бүрдлийн дүрэм, төсөв зохиох аргачлалыг төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

30 дугаар зүйл.Төмөр замын дэд бүтцийг хаах

30.1.Галт тэрэгний хөдөлгөөний эрчимжилт, төмөр замын дэд бүтцийн нийгэм, эдийн засгийн ач холбогдол буурсан тохиолдолд эзэмшигчийн хүсэлтээр дэд бүтцийг хаах эсэх асуудлыг Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага шийдвэрлэнэ.

30.2.Төмөр замын дэд бүтцийг хаахтай холбоотой харилцааг Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмаар зохицуулна.

31 дүгээр зүйл. Төмөр замын тээвэр дэх галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зохицуулалт

31.1.Төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаа хоногийн 24 цагийн туршид тасралтгүй явагдана.

31.2.Галт тэрэгний хөдөлгөөнийг техникийн нормчлолын дагуу зохиосон зурмагаар зохицуулна.

31.3.Техникийн нормчлолыг дор дурдсанаар боловсруулж мөрдөнө:

31.3.1.Төмөр замын дэд бүтэц нь өөрийн дэд бүтцийн жилийн техникийн нормчлолыг боловсруулан баталж, тухай бүр тодотгож мөрдөнө.

31.3.2.Төмөр замын дэд бүтцүүдийн техникийн нормчлолд үндэслэн галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв тухайн жилийн улсын нэгдсэн техникийн нормчлолыг боловсруулан баталж, тухай бүр тодотгоно.

31.4.Төмөр замын дэд бүтэц нь галт тэрэгний хөдөлгөөн удирдах диспетчерийн төвтэй байна.

31.5.Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмын дагуу төмөр замын дэд бүтэц хоорондын үйл ажиллагааны уялдааг хангаж, улсын хэмжээнд галт тэрэгний хөдөлгөөнийг нэгдсэн зурмагаар зохицуулна.

31.6.Төмөр замын дэд бүтэц эзэмшигч нь хэрэглэгчийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн өөрийн нэвтрүүлэх чадварыг тооцоолж, оновчтой ашиглах үүрэгтэй.

31.7.Төмөр замын дэд бүтцийн галт тэрэгний хөдөлгөөний зурмагийг боловсронгуй болгох саналыг төрийн болон орон нутгийн байгууллага, тээвэрлэгч, тээвэр зуучлагч, зорчигч, ачаа илгээгч, хүлээн авагч, иргэд гаргах эрхтэй.

31.8.Төмөр замын дэд бүтэц эзэмшигч саналыг хүлээж авсан өдрөөс 30 хоногийн дотор тухайн саналыг авч үзэн, хэрхэн шийдвэрлэсэн талаар санал гаргагчид хариу мэдэгдэх үүрэгтэй.

31.9.Санал гаргагч нь энэ тухай төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад гомдол гаргах эрхтэй.

31.10.Төрийн бус байгууллага, иргэн нь галт тэрэгний хөдөлгөөнийг зохицуулах ажлыг саатуулах, төмөр замын тээврийн тасралтгүй үйл ажиллагааг зогсоохыг хориглоно.

32 дугаар зүйл.Төмөр замын хөдөлгөөнийг түр хугацаагаар хязгаарлах, хаах

32.1.Төмөр замын дэд бүтэц эзэмшигч нь дор дурдсан тохиолдолд галт тэрэгний хөдөлгөөнийг түр хугацаагаар хязгаарлах, хаах арга хэмжээг авч болно:

32.1.1.төмөр замын дэд бүтцийг арчлах, засварлах, өргөтгөх ажлыг гүйцэтгэх;

32.1.2.төмөр замын дэд бүтэц, хөдлөх бүрэлдэхүүний техникийн байдлаас шалтгаалан хүмүүсийн амь нас эрүүл мэнд, байгаль орчин, эд хөрөнгөд шууд учрах аюулыг арилгах;

32.1.3.гамшиг, осол, аюулгүй байдал алдагдсан үйл явдал, цаг агаарын гэнэтийн өөрчлөлт, бусад хүчин зүйлийн нөлөөллөөс болж төмөр замын хөдөлгөөн саатуулсан урьдчилан тооцоолох боломжгүй нөхцөлийг арилгах;

32.1.4.бусад үндэслэл бүхий нөхцөл байдал үүсэх.

32.2.Галт тэрэгний хөдөлгөөнийг түр хугацаагаар хаах, хязгаарлах асуудлыг Төмөр замын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмаар зохицуулна.

ТАВДУГААР БҮЛЭГ ХӨДЛӨХ БҮРЭЛДЭХҮҮН, ЧИНГЭЛЭГ

33 дугаар зүйл.Хөдлөх бүрэлдэхүүн, чингэлэг

33.1.Хөдлөх бүрэлдэхүүн, чингэлэг нь өмчийн хэлбэрээс үл хамааран төмөр замын олон улсын гэрээ, хэлэлцээр, дүрэм, журам, энэ хууль, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль, Төмөр

замын техник ашиглалтын дүрэм, холбогдох бусад эрх зүйн актад заасан шаардлагад нийцсэн байна.

33.2.Хөдлөх бүрэлдэхүүн, чингэлэг нь Монгол Улсын хөдлөх бүрэлдэхүүн чингэлгийн нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн байна.

33.3.Хөдлөх бүрэлдэхүүн, чингэлгийн бүртгэлийн үйл ажиллагааг Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв улсын хэмжээнд нэгтгэн зохион байгуулна.

33.4.Хөдлөх бүрэлдэхүүн, чингэлгийн улсын нэгдсэн бүртгэлд бүртгэх, дугаар олгох харилцааг Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмаар зохицуулна.

33.5.Төмөр замын тээвэрт ашиглах хөдлөх бүрэлдэхүүн нь аюулгүй байдлын гэрчилгээ, техникийн байдлыг тодорхойлсон баримт бичигтэй байна.

33.6.Хөдлөх бүрэлдэхүүн, чингэлгийг улсын бүртгэлд бүртгэснийг нотолж гэрчилгээ олгоно.

33.7.Дараах хөдлөх бүрэлдэхүүн, чингэлгийг улсын бүртгэлд бүртгэхийг хориглоно:

33.7.1.Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөж байгаа стандартын шаардлага хангаагүй;

33.7.2.зохих хууль тогтоомжийн дагуу баримт бичгийн бүрдүүлэлт хийгээгүй, татвар төлөөгүй;

33.7.3.үйлдвэрлэгч, ашиглагч улсын төмөр замын байгууллагаас тээвэрлэлтэд явуулахыг хориглосон, улсын бүртгэлээс хассан;

33.7.4.хөдлөх бүрэлдэхүүн, чингэлгийн ашиглалтын хугацаа нь Олон Улсын гэрээ, хэлэлцээр, дүрэм, журамд заасан шаардлагад нийцээгүй;

33.7.5.техникийн үзүүлэлт нь техникийн баримт бичигтэй зөрсөн, хуурамчаар үйлдсэн болох нотлогдсон.

33.8.Энэ хуулийн 33.2-т заасан бүртгэлд бүртгэгдээгүй хөдлөх бүрэлдэхүүн, чингэлгийг төмөр замын тээвэрт ашиглахыг хориглоно.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ, ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭЛТ

34 дүгээр зүйл.Тусгай зөвшөөрлийн төрөл, ангилал

34.1.Төмөр замын тээврийн салбарт зарим үйл ажиллагаа эрхлэх, тодорхой эрх эзэмшиж, ашиглахад тусгай зөвшөөрөл олгоно.

34.2.Төмөр замын тээврийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл дор дурдсан төрөлтэй байна.

34.2.1.төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэх;

34.2.2.төмөр замын дэд бүтэц, салбар зам барих, ашиглах, засварлах, арчлах;

34.2.3.төмөр замын дэд бүтцийн иж бүрдлийг үйлдвэрлэх, угсрах, засварлах;

34.2.4.төмөр замын хөдлөх бүрэлдэхүүн, түүний эд анги, эдлэхүүнийг үйлдвэрлэх, угсрах, засварлах;

34.2.5.Төмөр замын дэд бүтэц, хөдлөх бүрэлдэхүүний зураг төсөл боловсруулах, техник технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ үзүүлэх;

34.2.6.төмөр замын дэд бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнд техникийн үзлэг, оношлогоо хийх.

34.3.Төмөр замын дэд бүтэц барих тусгай зөвшөөрлийг Засгийн газар олгоно.

34.4.Энэ хуулийн 34.3-т зааснаас бусад төмөр замын тээврийн үйл ажиллмагаагааны тусгай зөвшөөрлийг Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно.

35 дугаар зүйл.Тусгай зөвшөөрөл олгоход тавигдах нөхцөл, шаардлага

35.1.Төмөр замын дэд бүтэц барих тусгай зөвшөөрөл авах өргөдөл гаргахдаа Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд зааснаас гадна дор дурдсан баримт бичгийг бүрдүүлж, төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ:

35.1.1.зураг төсөл;

35.1.2.мэргэжилтний мэдээлэл;

35.1.3.үйлдвэрлэлийн байр, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, багаж, технологийн мэдээлэл;

35.2.Төмөр замын дэд бүтэц барих тусгай зөвшөөрлийг хянан шийдвэрлэх үед холбогдох төрийн захиргааны төв байгууллага дараах нөхцөл байдлыг шалгаж, дүгнэлт гаргана:

35.2.1.улс орны батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах, нийтийн эрх ашиг, хууль ёсны ашиг сонирхолд харшлах нөхцөл байдал байгаа эсэх;

35.2.2.эзэмшилд олгох газар нь улсын тусгай хэрэгцээний буюу бусдын эзэмшлийн газартай давхцаж байгаа эсэх;

35.2.3.байгаль орчны тэнцвэрт байдал алдагдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах эсэх;

35.2.4.Засгийн газрын үүрэг болгосон холбогдох бусад асуудал.

35.3.Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага нь тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ байгуулна.

35.4.Тусгай зөвшөөрөл эзэмшигч тусгай зөвшөөрлийн дагуу эрхэлсэн үйл ажиллагааны тайланг Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад дараа жилийн 1 дүгээр сард багтаан ирүүлж байх үүрэгтэй.

36 дугаар зүйл.Тусгай зөвшөөрлийг олгох, сунгах

36.1.Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага өргөдлийг энэ хуулийн 38.2-т заасан журмын дагуу хуанлийн 21 хоногийн дотор хянаж, санал, дүгнэлтийг Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

36.2.Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тусгай зөвшөөрөл олгох эсэх асуудлыг хуанлийн 14 хоногийн дотор шийдвэрлэнэ.

36.3.Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь төмөр замын дэд бүтэц барих тусгай зөвшөөрлийн талаарх саналыг хуанлийн 14 хоногийн дотор хянаж, дүгнэлтийн хамт Засгийн газарт хүргүүлнэ.

36.4.Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах тухай өргөдлийг тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас хуанлийн 30 хоногийн өмнө Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад гаргаж, эрх бүхий байгууллага тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах эсэх асуудлыг хуанлийн 14 хоногийн дотор шийдвэрлэнэ.

37 дугаар зүйл.Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх

37.1.Төмөр замын тээврийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээхтэй холбоотой харилцааг энэ хуулийн 38.2-т заасан журмаар зохицуулна.

38 дугаар зүйл.Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох

38.1.Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах тохиолдолд төмөр замын тээврийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, нийтэд мэдээлнэ:

38.1.1.төмөр замын тээврийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд Төмөр замын тээврийн салбарын статистик мэдээ, үйл ажиллагааны тайлангаа 1 (нэг) жилээс дээш хугацаанд Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлээгүй бол Зөрчлийн тухай хуульд заасны дагуу арга хэмжээ авах;

38.1.2.тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагааг нэг жилийн турш эрхлээгүй;

38.1.3.тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд нь тусгай зөвшөөрлийн гэрчилгээг гэсэн, үрэгдүүлсэн шалтгаанаар нөхөн олгуулах хүсэлт гаргасан бол гэрчилгээгээ гэсэн тухай өдөр тутмын сонинд зарлуулж, нотлох баримтын хамт нөхөн олгох хүсэлтийг эрх бүхий байгууллагад ирүүлнэ.

38.2.Энэ хуулийн 34.2-т заасан тусгай зөвшөөрлийн төрөл тус бүрийн ангилал, тэдгээрт тавигдах нөхцөл, шаардлага болон тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбоотой Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль болон энэ хуульд зааснаас бусад харилцааг Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмаар зохицуулна.

39 дүгээр зүйл.Төмөр замын тээврийн салбар дахь гэрчилгээжүүлэлт

39.1.Төмөр замын дэд бүтэц ашиглуулах, ачаа болон зорчигч тээвэрлэлтийн үйлчилгээ үзүүлэх этгээд нь төмөр замын тээврийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлөөс гадна итгэмжлэгдсэн байгууллагаас олгосон бүтээгдэхүүн, ажилтны ур чадвар, менежментийн тогтолцооны тохирлын үнэлгээний гэрчилгээтэй байна.

39.2.Тохирлын үнэлгээ хийх төмөр замын тээврийн салбарын бүтээгдэхүүн, ажилтан, менежментийн тогтолцооны жагсаалтыг Засгийн газар батална.

39.3.Энэ хуулийн 39 дүгээр зүйлд заасан тохирлын үнэлгээтэй холбоотой харилцааг Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулиар зохицуулна.

ДОЛДУГААР БҮЛЭГ ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВЭРЛЭЛТ

40 дугаар зүйл. Төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагааны төрөл

40.1.Төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаа нь дараах төрөлтэй байна:

40.1.1.зорчигч тээвэрлэлт;

40.1.2.ачаа тээвэрлэлт;

40.1.3.тусгай тээвэрлэлт.

Нэгдүгээр дэд бүлэг.Зорчигч тээвэрлэлт

41 дүгээр зүйл. Зорчигч тээврийн бодлого, зохицуулалт

41.1.Олон улсад болон Монгол Улсын нутаг дэвсгэрт зорчигч тээвэрлэлт гүйцэтгэх асуудлыг төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар шийдвэрлэнэ.

42 дугаар зүйл.Зорчигч, тээш, ачаан тээш тээвэрлэлт

42.1.Зорчигч тээвэрлэлтийн үйлчилгээг тээвэрлэгчээс зорчигчид олгосон зорчих тасалбарын үндсэн дээр үзүүлнэ.

42.2.Зорчих тасалбар (цаасан болон цахим) нь зорчигч болон тээвэрлэгчийн хооронд тээвэрлэлтийн гэрээ байгуулсныг нотлох баримт бичиг мөн.

42.3.Зорчигч тээвэрлэх гэрээний дагуу зорчигч нь зорчих тасалбарын үнийг төлөх, тээвэрлэгч нь зорчигчийг хүрэх газарт хүргэх, галт тэргэнд зорчих тасалбарт заасан суудлаар хангах үүрэгтэй.

42.4.Тээш, ачаан тээш тээвэрлэх гэрээний дагуу тээвэрлэгч нь тээш, ачаан тээшийг хүрэх газарт хүргэх, илгээгч ачаа хүргэлтийн төлбөрийг төлөх үүрэгтэй.

42.5.Тээш, ачаан тээшийн төлбөрийн баримт нь тээш, ачаан тээш тээвэрлэх гэрээ байгуулсныг нотлох баримт бичиг болно.

42.6.Тээвэрлэгч нь зорчих тасалбарыг тасалбар худалдаалах төв, цахим терминал, интернетээр болон бусад аргаар худалдаалах ажлыг зохион байгуулна.

42.7.Зорчих тасалбар худалдаалалт болон суудал нөөцлөлтийг төмөр замын зорчигч үйлчилгээ, бүртгэлийн хагас болон бүрэн автоматжуулсан системээр гүйцэтгэнэ.

42.8.Тээвэрлэгч нь зорчих тасалбарын дагуу зорчигчийг хүрэх газарт хүргээгүй эсхүл тээвэрлэлтийг үргэлжлүүлэхээс татгалзсан бол хүрэх газарт нь хүрэх хүртэлх зорчигчид гарч болох бүхий л зардлыг гэрээний дагуу төлөх үүрэгтэй.

43 дугаар зүйл.Зорчигч, тээш, ачаан тээш тээвэрлэх дүрэм

43.1.Төмөр замаар зорчигч, тээш, ачаан тээш тээвэрлэх дүрмийг Засгийн газар батална.

43.2.Зорчигч, тээш, ачаан тээш тээвэрлэх дүрмээр дараах харилцааг зохицуулна.

43.2.1.зорчигчийн тасалбар худалдаалах, хугацаа сунгах, тасалбар худалдаалах нэгжийн ажлын горим;

43.2.2.зорчигчийн вагоны зэрэглэл;

43.2.3.зорчигч үйлчилгээний цогцолбор болон зорчигчийн галт тэргэнд заавал үзүүлэх үйлчилгээний жагсаалт;

43.2.4.зорчих нөхцөл, түүнийг өөрчлөх, цагаан хэрэгсэл олгох болон галт тэргэн дэх бусад нэмэлт үйлчилгээ үзүүлэх журам;

43.2.5.зорчигчийн авч явах гар тээштэй холбоотой зохицуулалт;

43.2.6.тээш, ачаан тээш хүлээж авах, олгох журам;

43.2.7.тээш, ачаан тээш тээвэрлэлтийн бичиг баримтын маягт, түүнийг бүрдүүлэх журам;

43.2.8.зорчигчийн галт тэргээр тээвэрлэх амьтны жагсаалт, тээвэрлэх журам;

43.2.9.зорчигч тээвэрлэлтийн явцад тээш, ачаан тээш олгох журам;

43.2.10.тээш, ачаан тээшийг тээвэрлэлтийн явцад шилжүүлэн зөөвөрлөх журам;

43.2.11. тээш, ачаан тээшийг хадгалах, саатуулах, дамжуулах журам;

43.2.12.аюултай бодис, эд зүйл тээвэрлэх журам;

43.2.13.зорчих тасалбар ашиглаагүй тохиолдолд буцаалт хийх журам;

43.2.14.насан хүрээгүй зорчигч тээвэрлэх журам;

43.2.15.зорчигчийн тавцан ашиглах журам;

43.2.16.хууль тогтоомжид заасан бусад.

44 дугаар зүйл. Зорчигчийн галт тэргэнд хийх хяналт шалгалт

44.1.Зорчигчийн галт тэргэнд зорчигч, тээш, ачаан тээш тээвэрлэх дүрэм хэрхэн хэрэгжиж байгааг энэ хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хуульд заасан эрх бүхий албан тушаалтан шалгалт хийж акт үйлдэнэ.

44.2.Зорчигчийн галт тэргэнд хяналт шалгалт эхлэхийн өмнө албан тушаалтан шалгалт хийх эрхтэйг нотлох бичиг баримт болон шалгалтын талаар галт тэрэгний дарга, бие бүрэлдэхүүнд танилцуулна.

44.3.Хэрвээ шалгалт хийх эрх бүхий албан тушаалтанд шалгалт хийхэд нь саад учруулбал энэ тухай тэмдэглэл үйлдэнэ. Шалгалт хийхэд саад учруулах нь шалгалт хийхгүй байх үндэслэл болохгүй.

44.4.Галт тэрэг хөдөлсний дараа шалгалтыг эхлүүлж бүх вагонд үзлэг шалгалт хийнэ.

44.5.Зорчигчийн галт тэргэнд шалгалт хийсэн үр дүнгийн актыг 2 хувь үйлдэнэ.

44.6.Актын нэг хувийг галт тэрэгний даргад гардуулна.

44.7.шалгалт хийсэн тухай актад дараах мэдээллийг тусгана:

44.7.1.акт үйлдсэн огноо, дугаар;

44.7.2.эрх бүхий байгууллагын нэр;

44.7.3.эрх бүхий албан тушаалтны нэр, овог нэр;

44.7.4.зорчигчийн галт тэргэнд шалгалт хийсэн тухай актын бүртгэлийн дугаар;

44.7.5.шалгалт хийсэн галт тэрэгний нэр, дугаар;

44.7.6.шалгуулж байгаа этгээдийн овог нэр, ажил, албан тушаал, ажлын үнэмлэхний дугаар;

44.7.7.шалгалтын агуулга, хамрах хүрээ;

44.7.8.шалгалт хийсэн хугацаа;

44.7.9.шалгалт хийсэн албан тушаалтны гарын үсэг, эрх бүхий байгууллагын тамга, тэмдэг.

45 дугаар зүйл.Зорчигчийн эрх, үүрэг

45.1.Зорчигч дараах эрхтэй:

45.1.1.бүх төрлийн галт тэрэг, вагонд тасалбар худалдан авах;

45.1.2.худалдан авсан тасалбарын дагуу галт тэрэгний вагонд суудал авах;

45.1.3.тав хүртэлх насны тусдаа суудал эзлэхгүй нэг хүүхдийг үнэ төлбөргүй харгалзан авч явах;

45.1.4.таваас арван хоёр насны хүүхдийг хөнгөлттэй үнээр хамт харгалзан авч явах;

45.1.5.хүүхдийн тасалбараар 36 кг-аас хэтрэхгүй гар тээш үнэгүй авч явах;

45.1.6.хөгжлийн бэрхшээлтэй болон хязгаарлагдмал хөдөлгөөнтэй зорчигч нь туслах хэрэгсэл (тэргэнцэр, таяг гэх мэт)-ийг үнэ төлбөргүй авч явах;

45.1.7.зорчигч тээвэрлэлтийн дүрэмд заасан ёсоор тасалбарыг буцаах, тээвэрлэгчээс тасалбарын болон тээш тээвэрлэлтийн үнийг буцааж авах, тасалбарын хугацааг сунгах;

45.1.8.аяллын зам зуурт буух (зорчигч тээвэрлэх дүрэмд заасны дагуу);

45.1.9.өмнөх галт тэргээр зорчих тасалбар (сул суудалтай тохиолдолд тасалбарт өөрчлөлт оруулан)-аар дараагийн галт тэргээр аялах;

45.1.10.зорчих тасалбарыг хаясан үрэгдүүлсэн бол зорчигч тээвэрлэх дүрэмд заасны дагуу тээвэрлэгчид бичгээр хүсэлт гарган, тасалбарын хувийг авах.

45.2.Зорчигч нь дараах үүрэгтэй:

45.2.1.тасалбар худалдаж авах, галт тэргэнд суух, эсхүл аяллын зам зуурт тасалбар шалгуулах үедээ хувийн бичиг баримтаа үзүүлэх;

45.2.2.галт тэргэнд суух болон аяллын хугацаанд тасалбарыг биедээ авч явах;

45.2.3.зорчигч үйлчилгээний цогцолборын болон зорчигчийн вагон ашиглах журам, нийтийн хэв журмыг сахин биелүүлэх;

45.2.4.тээвэрлэгчийн эд хөрөнгөнд ариг гамтай хандаж, эвдэж гэмтээхгүй байх;

45.2.5.галын аюулгүй байдлыг хангах.

46 дүгээр зүйл.Тээш, ачаан тээш тээвэрлэлт

46.1.Тээвэрлэгч нь зорчигч болон илгээгчээс тээш, ачаан тээшийг хүлээн авч төмөр замын өртөө (уг ажиллагаанд нээлттэй) хүртэл тээвэрлэх үүрэгтэй.

46.2.Зорчих тасалбартай этгээд нь тээшийн вагонд 36 кг-аас илүүгүй жинтэй, 40х60х80 см хэмжээтэй гар тээшийг үнэгүй тээвэрлүүлж болно.

46.3.Тээш, ачаан тээшийн ачаан төлбөрийн баримт нь тээвэрлэлтийн гэрээ байгуулсныг нотлох бичиг баримт мөн. Ачаан тээш тээвэрлэхэд зорчигчийн тасалбар шаардахгүй.

46.4.Тээвэрлэгч нь илгээгчийн тээш, ачаан тээшийг тээшийн вагон холбогдсон хамгийн эхний галт тэргээр явуулах боловч зорчигчийн тээш, ачаан тээшийг тэргүүн ээлжинд илгээх зарчим баримтална.

46.5.Зорчигчийн тасалбарт заасан замналаар явуулах тээш, ачаан тээшийг зорчигчийн зорчиж байгаа галт тэргээр, эсхүл тээшийн вагон холбогдсон эхний галт тэргээр явуулна.

46.6.Зорчигч (илгээгч) тээшийг тээвэрлэлтэд хүлээлгэн өгөхдөө үнэ зарлаж болно. Ачаан тээшийг тээвэрлэлтэд хүлээлгэн өгөхдөө заавал үнэ зарлана.

46.7.Тээвэрлэлтэд тээш, ачаан тээшээр хүлээлгэн өгч байгаа эд хөрөнгө нь хэмжээ, сав, баглаа боодол, шинж чанарын хувьд тээшийн вагонд ачиж буулгахад хүндрэл үүсгэхгүй, тээвэрлэгчийн эд зүйл, бусад зорчигчийн тээш, ачаан тээшийг гэмтээхээргүй байна.

47 дугаар зүйл.Тээш, ачаан тээшийг хүргэх хугацаа

47.1.Тээш, ачаан тээшийн хүргэх хугацааг галт тэрэгний зурмагт нийцүүлэн хүрэх өртөө хүртэл зорчигчийн галт тэрэг явах хугацаагаар тодорхойлно.

47.2.Тээш, ачаан тээшийг аяллын зам зуурт шилжүүлэн ачих бол шилжүүлэн ачилт тутамд хүргэх хугацааг нэг хоногоор нэмж тооцно.

47.3.Тээш, ачаан тээшийг хүрэх өртөөнд зорчигч, хүлээн авагчид тээш, ачаан тээшийн болон зорчигчийн тасалбарыг үндэслэн хувийн бичиг баримтыг нь шалгаж олгоно.

48 дүгээр зүйл.Тээш, ачаан тээшийг хадгалах хугацаа дууссаны үр дагавар

48.1.Зорчигч, хүлээн авагч нь тээвэрлэгчээс үл хамаарах шалтгаанаар тээш, ачаан тээшээ аваагүй тохиолдолд тээвэрлэгч уг тээш, ачаан тээшийг ирсэн өдрөөс хойш хуанлийн 30 хоногийн хугацаанд хүрэх өртөөнд хадгалах үүрэгтэй.

48.2.Гаалийн хяналтад байгаа тээш, ачаан тээшийг хуанлийн 15 хоног хадгалах үүрэгтэй.

48.3.Энэ хуулийн 51.1, 51.2-т заасан хадгалах хугацаа дуусмагц тээвэрлэгч төрийн эрх бүхий байгууллагын мэдэлд тээш, ачаан тээшийг шилжүүлнэ. Шилжүүлсэн үеэс зорчигч, илгээгч, хүлээн авагч тээш, ачаан тээшийг авах, түүний үнийг нөхөн төлүүлэх асуудлаар холбогдох төрийн байгууллагад хандах эрхтэй.

Хоёрдугаар дэд бүлэг.Ачаа тээвэрлэлт

49 дугаар зүйл.Ачаа тээвэрлэлтийн гэрээ

49.1.Ачаа тээвэрлэлтийн гэрээнд заасны дагуу тээвэрлэгч нь хүлээн авсан ачааны бүрэн бүтэн байдлыг хангаж, тээвэрлэлтийн нөхцөлийг мөрдөх, хүрэх өртөөнд ачаа хүлээн авагчид хугацаанд нь хүргэх, ачаа илгээгч (хүлээн авагч) нь ачаа тээвэрлэлтийн хөлс төлөх, ачаа хүлээн авах үүргийг тус тус хүлээнэ.

49.2.Төмөр замын ачаа тээвэрлэлтийн гэрээ байгуулсныг нотлох баримт нь төмөр замын тээврийн падаан юм.

49.3.Падааныг ачаа илгээгч үйлдэж, тээвэрлэгчид хүлээлгэн өгнө.

49.4.Дараах баримт нь ачаа тээвэрлэлтийн баримт бичгийн иж бүрдэлд багтана:

- 49.4.1.төмөр замын тээврийн падаан;
- 49.4.2.замын хүснэгт;
- 49.4.3.орлох падаан;
- 49.4.4.ачаа олгох хуудас.

49.4.5. ачаа ирсэн тухай мэдэгдэх хуудас.

49.5. Илгээх өртөөний хуанлийн тэмдгийг төмөр замын тээврийн падаанд дарж, ачааг тээвэрлэлтэд хүлээн авч төлбөрийн баримтыг ачаа илгээгчид хүлээлгэн өгснөөр тээвэрлэлтийн гэрээ байгуулагдсанд тооцно.

50 дугаар зүйл. Тээвэрлэлтийн гэрээний нөхцөлийг өөрчлөх (хаяг солих)

50.1. Ачаа тээвэрлэлтийн гэрээний нөхцөлийг өөрчлөх, ачааны хаяг солих ажиллагааг ачаа тээврийн дүрэмд заасны дагуу талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр хийнэ.

50.2. Хаяг солих эрхийг ачаа илгээгч эдлэх ба ачаа тээвэрлэх дүрмийн дагуу тээвэрлэгчид хүсэлт гаргаж, харилцан тохиролцсоны үндсэн дээр шийдвэрлэнэ.

50.3. Гаалийн хяналтад байгаа ачааны хаяг солих ажиллагааг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэйгөөр гүйцэтгэнэ.

50.4. Гаалийн хяналтад байгаа ачаа тээвэрлэлт нь хүний амь нас, эрүүл мэнд, хөдөлгөөний болон хүрээлэн байгаа орчны аюулгүй байдал, ачааны чанар, бүрэн бүтэн байдалд заналхийлсэн тохиолдолд эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хаяг солих ажиллагааг гүйцэтгэх бөгөөд ачаа тээвэрлэх дүрэмд заасан хугацаанд энэ тухай заавал мэдэгдэнэ.

50.5. Ачааг үргэлжлүүлэн тээвэрлэх нь ачааны бүрэн бүтэн байдал болон хөдөлгөөний аюулгүй байдалд аюул, занал учруулж болзошгүй тохиолдолд илгээгч (хүлээн авагч)-ийн зөвшөөрөлтэйгөөр тээвэрлэгч ачааг шилжүүлэн ачих эрхтэй.

50.6. Ачаа илгээгчийн ломботой ачааг хөдлөх бүрэлдэхүүний гэмтлээс шалтгаалан тээвэрлэлтийн явцад шилжүүлэн ачиж, тээвэрлэгчийн ломбоор ломбодсон тохиолдолд хүрэх өртөөнд тээвэрлэгчийн төлөөлөгчийг байлцуулан ачааг хүлээлгэн өгнө.

50.7. Хууль тогтоомжид тусгайлан заасан тохиолдолд төрийн эрх бүхий байгууллага тээвэрлэгчийн ачааг хураах эрхтэй. Ачааг хураан авсан тохиолдолд тээвэрлэгч нь тээврийн хөлс, ачаа хадгалалтын хөлс болон өөрт учирсан бусад хохирлыг буруутай этгээдээр нөхөн төлүүлэх эрхтэй.

51 дүгээр зүйл. Ачаа тээвэрлэлтийг зохион байгуулах гэрээ

51.1. Ачаа тээвэрлэлт зохион байгуулах гэрээний дагуу ачаа илгээгч нь ачааг тээвэрлэгчид хүлээлгэн өгөх, тээвэрлэгч нь ачааг хүлээж авах, хүргэх үүрэгтэй.

51.2. Ачаа тээвэрлэлтийг зохион байгуулах гэрээгээр тусгай тээвэрлэлтийн гэрээнээс бусад тохиолдолд тээврийн хэмжээ, хугацаа, тээвэрлэлтийн чанар, ачааг тээвэрлэлтэд бэлтгэх нөхцөл болон энэ хуульд заагаагүй тээвэрлэлтийг зохион байгуулах бусад нөхцөл зэргийг тусгана.

51.3. Тээвэрлэгч болон ачаа илгээгч нь байнгын тогтмол тээвэрлэлт хийх зорилгоор тээвэрлэлтийг зохион байгуулах урт хугацааны гэрээ байгуулж болно.

52 дугаар зүйл. Эрх, үүргээ шилжүүлэх

52.1.Ачаа ирсэн тухай ачаа хүлээн авагчид мэдэгдсэн үеэс тээвэрлэлтийн гэрээнд заагдсан ачаа илгээгчийн эрх, үүрэг ачаа хүлээн авагчид шилжинэ.

52.2.Ачаа илгээгчийн буруутай үйл ажиллагаанаас тээвэрлэгчид төлсөн зардлыг ачаа хүлээн авагч илгээгчээс шаардах эрхтэй.

53 дугаар зүйл.Ачаа тээвэрлэх дүрэм

53.1.Ачаа тээвэрлэх дүрмийг Засгийн газар батална. Дүрмээр ачаа тээвэрлэлттэй холбоотой дараах харилцааг зохицуулна.

- 53.1.1.тээвэрлэлтийн ажлын төлөвлөлт;
- 53.1.2.тээвэрлэлтийн төлөвлөгөө, гэрээний биелэлтийн тооцооны карт хөтлөх;
- 53.1.3.ачааг тээвэрлэлтэд хүлээн авах;
- 53.1.4.ачааг олгох;
- 53.1.5.вагон, чингэлгийг битүүмжлэх, ломбо тавих;
- 53.1.6.тээвэрлэлтийн баримт бичгийн иж бүрдлийг бүрдүүлэх;
- 53.1.7.их хэмжээний ачааг замналаар, бүлэг вагоноор, нэг падаанаар тээвэрлэх;
- 53.1.8.үнэ зарласан ачаа тээвэрлэх;
- 53.1.9.вагон жинд ачааг жинлэх;
- 53.1.10.ачааны жингийн хэвийн хорогдлын хэмжээг тодорхойлох аргачлал;
- 53.1.11.вагон тавих, татах гэрээ байгуулах;
- 53.1.12.ачаа ачиж, буулгах ажлын нормт хугацаа;
- 53.1.13.ачаа хүргэх хугацаа болон ачаа хүргэх хугацааг тооцох журам;
- 53.1.14.ачааг хадгалах журам;
- 53.1.15.ачааг саатуулах, худалдах, эрх бүхий төрийн байгууллагад шилжүүлэх;
- 53.1.16.ачааны хаяг солих, илгээгч рүү буцаах журам;
- 53.1.17.нурмаг, нунтаг овоолмог ачааг тээвэрлэх;
- 53.1.18.задгай хөдлөх бүрэлдэхүүнээр ачаа тээвэрлэх;
- 53.1.19.ачаа хүргэгчтэйгээр тээвэрлэх;
- 53.1.20.илгээгчийн замналаар тээвэрлэх;
- 53.1.21.жижиг (түүвэр) илгээлтээр тээвэрлэх;
- 53.1.22.чингэлэгээр болон баглаа, боодолтойгоор тээвэрлэх;
- 53.1.23.дулааны болон агааржуулалтын горим баримтлан тээвэрлэх;
- 53.1.24.түргэн муудах ачаа тээвэрлэх;
- 53.1.25.мал, амьтан, шувуу тээвэрлэх;
- 53.1.26.мал эмнэлэг, ургамал хорио цээрийн хяналтад байгаа ачаа тээвэрлэх;
- 53.1.27.тээвэрлэлттэй холбоотой акт үйлдэх;
- 53.1.28.цистерн болон бункер вагонд шингэн ачаа тээвэрлэх;
- 53.1.29.аюултай ачаа тээвэрлэх;
- 53.1.30.ачаа тээвэрлэлттэй холбоотой туршилт, судалгаа явуулах;
- 53.1.31.онцгой нөхцөлд ачаа тээвэрлэх;
- 53.1.32.ачааг буулгасны дараа вагон, чингэлгийг цэвэрлэх, угаах, ариутгах;
- 53.1.33.хууль тогтоомжид заасан бусад нөхцөл.

54 дугаар зүйл. Ачаа ачих, буулгах үйл ажиллагаа

54.1.Тээвэрлэгч, ачаа илгээгч, хүлээн авагч нь ачааны ачилт, буулгалтын ажлыг Ачаа тээвэрлэлтийн дүрэм, гэрээнд заасан хугацаа, нөхцөлийн дагуу гүйцэтгэнэ.

54.2.Гаалийн хяналт шалгалт хийх зорилгоор вагон, чингэлэгт ачаа, ачаан тээш ачих, буулгах ажлыг тээвэрлэлтэд оролцогч гаалийн байгууллагын зөвшөөрсөн хяналтын талбай, салбар зам дээр гүйцэтгэнэ.

54.3.Төрийн хяналт шалгалтын байгууллагын санаачлагаар хяналт шалгалт хийх үед ачааг ачиж буулгах, хадгалах, вагон тавилт, таталт хийх, барааг дахин савлах, сав баглаа, боодлыг нээх, гэмтсэн сав баглаа боодлыг солихтой холбоотой үүссэн тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогчийн зардлыг хууль тогтоомжид заасны дагуу ачаа илгээгч, ачаа хүлээн авагчийн зардлаар нөхөн олгоно.

54.4.Ачаа илгээгч нь ачаа ачих явцад ачааг зөв байрлуулах, бэхлэх, зохих тээврийн хэрэгсэл, задгай хөдлөх бүрэлдэхүүнд ачих машин механизм, хүнд жинтэй болон хэтрүү овортой ачааны ачилтын норм, техникийн нөхцөлийг хангах болон тээвэрлэгчийн баталсан ачилтын схемд нийцүүлэн ачих үүрэгтэй.

54.5.Ачаа вагон хүлээлцэгч болон ачаа тээврийн ажилтан ачааг зөв ачих, бэхлэх талаар ачаа илгээгчид зөвөлгөө өгч болно.

54.6.Тээвэрлэгч ачааг явуулахын өмнө ачааны бүрэн бүтэн болон галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахын тулд тогтоосон норм, схемийн дагуу зөв ачигдаж бэхэлсэн эсэхийг шалгах үүрэгтэй.

54.7.Ачаа илгээгч нь хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, ачаа болон хөдлөх бүрэлдэхүүний бүрэн бүтэн байдлыг хангахуйцаар ачааг тээвэрлэлтэд бэлтгэх үүрэгтэй.

54.8.Ачаа хүлээн авагч нь түүний хаягаар ирсэн ачааг хүлээн авах, хөдлөх бүрэлдэхүүнийг суллаж, цэвэрлэх үүрэгтэй.

55 дүгээр зүйл.Ачаа тээврийн төлөвлөлт

55.1.Ачаа тээвэрлэлтийг дор дурдсан гэрээний үндсэн дээр гүйцэтгэнэ:

55.1.1.ачаа тээвэрлэлтийн гэрээ (падаан);

55.1.2.ачаа тээвэрлэлтийг зохион байгуулах гэрээ.

55.2.Ачаа тээвэрлэлтийн гэрээг илгээгчээс өгөгдсөн тээвэрлэлтийн захиалгад үндэслэн байгуулна.

55.3.Ачаа тээвэрлэх захиалгын маягт, маягтыг бүрдүүлэх, бөглөх, өөрчлөлт оруулах, бүртгэх журмыг ачаа тээвэрлэх дүрмээр тогтооно.

55.4.Олон улсын харилцаанд ачаа тээвэрлэх захиалга өгөх ажиллагааг Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээний дагуу гүйцэтгэнэ.

55.5.Энэ хууль болон ачаа тээвэрлэх дүрэмд заасны дагуу тээвэрлэгч нь ачаа тээвэрлэх захиалгыг хүлээн авахаас татгалзаж болно.

56 дүгээр зүйл.Төмөр замын тээврийн падаан

56.1.Ачаа илгээгч нь ачааг тээвэрлэлтэд өгөхдөө илгээлт тус бүрд төмөр замын тээврийн падаан бичиж тээвэрлэгчид өгөх үүрэгтэй. Шаардлагатай тохиолдолд хууль тогтоомжид заасны дагуу бусад баримт бичиг (барааны гарал үүслийн гэрчилгээ, лиценз, мал эмнэлгийн гэрчилгээ, гаалийн мэдүүлэг)-ийг өгнө.

56.2.Гаалийн мэдүүлгийг цахим хэлбэрээр бүрдүүлсэн тохиолдолд төрийн байгууллагуудын мэдээллийн нэгдсэн системийг ашиглан барааг гаргах тухай цахим мэдэгдлийг тээвэрлэгчид өгнө.

56.3.Төмөр замын тээвэрлэлтийн баримт бичгийн иж бүрдлийн маягт, тэдгээрийг бүрдүүлэх журмыг ачаа тээвэрлэх дүрмээр тодорхойлно.

56.4.Төмөр замын падаанд заасан мэдээллийн үнэн зөвийг болон алдаатай, дутуу мэдээлэл падаанд оруулснаас үүсэх хариуцлагыг хууль, гэрээнд өөрөөр заагаагүй бол ачаа илгээгч хүлээнэ.

57 дугаар зүйл.Тээврийн бичиг баримтыг шалгах

57.1.Тээвэрлэгч нь төмөр замын тээврийн падаанд заасан мэдээллийн үнэн зөвийг шалгах үүргээ хэрэгжүүлэхдээ дараах эрхийг эдэлнэ:

57.1.1.ачааг шалгах;

57.1.2.ачаа илгээгч, хүлээн авагч, тээвэр зуучлагч, хөдлөх бүрэлдэхүүн, чингэлгийн оператор болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн магадалгаа (дахин бүртгүүлсэн)-г гаргуулан авах;

57.1.3.ачаа тээвэрлэгч, хүлээн авагч, тээвэр зуучлагч болон хөдлөх бүрэлдэхүүн, чингэлгийн операторын үүрэг гүйцэтгэж байгаа этгээдийн бичиг баримт, итгэмжлэл, бусад нотлох баримтыг шалгах.

57.2.Ачаа илгээгч, хүлээн авагч, тээвэр зуучлагчийн төлөөлөгч нь ачааг хүлээн авах, илгээх эрхийг баталгаажуулсан эрх бүхий этгээдээс олгосон итгэмжлэлтэй байна.

57.3.Ачаа илгээгч, хүлээн авагч, тээвэр зуучлагч нь энэ зүйлийн 60.2-т заасан мэдээлэлд орсон өөрчлөлтийн тухай тээвэрлэгчид ачаа хүлээн авах, олгохоос өмнө мэдэгдэх үүрэгтэй.

58 дүгээр зүйл.Вагон, чингэлгийг тавьж өгөх, татаж авах

58.1.Тээвэрлэгч нь гэрээ болон захиалгад заасан хугацаанд ачаа илгээгчид вагон, чингэлгийг ачилтад тавьж өгөх, татаж авах үүрэгтэй.

58.2.Вагон, чингэлгийг ачилтад бэлтгэхтэй холбоотой гарсан төлбөрийг гэрээний дагуу ачаа тээвэрлэх дүрэмд заасан хугацаанд, тухайн вагон, чингэлгийг өмчлөгч эсхүл хууль ёсоор эзэмшиж байгаа этгээд төлнө.

58.3.Ачаа илгээгч нь тээвэрлэгчийн хүч хэрэгслээр ачилтыг гүйцэтгэхээс бусад тохиолдолд захиалсан ачааны тээвэрлэлтэд вагон, чингэлэг коммерын хувьд тохирох эсэхийг тодорхойлно.

58.4.Ачаа илгээгч нь тухайн ачааг тээвэрлэхэд тэнцэхгүй вагон, чингэлгийг ашиглахаас татгалзах эрхтэй.

59 дугаар зүйл.Салбар зам

59.1.Салбар зам, түүний байгууламж, төхөөрөмж нь ачаа эргэлтэд нийцсэн ачилт, буулгалт, сэлгээний ажлын тогтмол, жигд үйл ажиллагааг хангаж, хөдлөх бүрэлдэхүүнийг оновчтой ашиглах боломжийг бүрдүүлсэн байна.

59.2.Салбар зам, түүний байгууламж, төхөөрөмж нь барилгын норм дүрэм, төмөр замын техник ашиглалтын болон холбогдох дүрэм, журам, стандартад нийцсэн байхаас гадна төмөр замын дэд бүтцэд ашиглаж байгаа хөдлөх бүрэлдэхүүнийг салбар замд ашиглах техникийн боломжийг хангасан байна.

59.3.Барих, сэргээж барих салбар замыг нийтийн хэрэгцээний төмөр замын дэд бүтцийн өртөөний замд холбох асуудлыг Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага холбогдох төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд, төмөр замын дэд бүтэц эзэмшигчтэй хамтран шийдвэрлэнэ.

59.4.Энэ хуулийн 62.3-т заасны дагуу салбар замыг нийтийн хэрэгцээний төмөр замын дэд бүтцийн өртөөний замд холбох асуудлыг шийдвэрлэхдээ төмөр замын дэд бүтцийн болон нийслэл, сум, дүүргийн хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, дэд бүтцийн ажлын технологид үзүүлэх сөрөг нөлөөллийг харгалзан үзнэ.

59.5.Салбар замыг шинээр барих, өргөтгөхтэй холбогдуулан уг замыг холбох өртөөний замд нэмэлт, өөрчлөлт хийх зардлыг салбар зам холбох хүсэлт гаргасан этгээд хариуцна.

59.6.Салбар замыг барих, ашиглах, нээх, хаах, шинэчлэх, засварлахтай холбоотой харилцааг Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмаар зохицуулна.

59.7.Төмөр замын дэд бүтэц эзэмшигч (тээвэрлэгч), салбар зам эзэмшигч хоорондын тээвэрлэлтийн үйл ажиллагаатай холбоотой харилцааг тэдгээрийн хооронд байгуулсан салбар зам ашиглах, арчлах, вагон тавих, татах гэрээгээр зохицуулна.

59.8.Салбар зам эзэмшигч нь хөдөлгөөний болон хөдөлмөрийн аюулгүй байдлын шаардлагыг биелүүлж, өөрийн зардлаар зам, байгууламж, төхөөрөмжийг арчлах, ачилт буулгалтын зам талбайг гэрэлтүүлэх, цас, мөс, хогийг цэвэрлэх үүрэгтэй.

59.9.Салбар зам нь зам, ачих, буулгах төхөөрөмжийн техникийн паспорт, замын дагуу огтлолын гүйцэтгэлийн зураг, хиймэл төхөөрөмжийн зураг, эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас гаргасан дүгнэлт, байнгын ашиглалтад хүлээж авсан акт зэрэг бичиг баримтаас бүрдсэн хувийн хэрэгтэй байна.

59.10.Салбар замын аюулгүй байдлын хяналтыг энэ хуулийн 11.4-т заасан хяналтын нэгж хэрэгжүүлнэ.

60 дугаар зүйл.Вагон, чингэлгийг ломбодох

60.1.Ачааг тээвэрлэгчийн хүч хэрэгслээр ачсан тохиолдолд тээвэрлэгчийн ломбо, ачаа илгээгч ачааг ачсан тохиолдолд ачаа илгээгчийн ломбоор ломбодно.

60.2.Гаалийн үзлэг, шалгалт хийх зорилгоор вагон, чингэлгийг нээсний дараа ачаа тээвэрлэх дүрэмд заасны дагуу тухайн вагон, чингэлгийг төрийн эрх бүхий байгууллагаас дахин ломбодно. Энэхүү ломбыг тээвэрлэгч болон ачаа илгээгчийн ломботой адилтган үзнэ.

60.3.Төрийн эрх бүхий байгууллагаас үзлэг, шалгалт хийж ачаа илгээгчийн ломбыг явуулах өртөөнөөс бусад газарт сольсон тохиолдолд ерөнхий маягтын акт тавьж тээвэрлэлтийн бичиг баримтад хавсаргана. Энэ тохиолдолд тээвэрлэгчийн ломбыг илгээгчийн ломботой адилтган үзнэ.

61 дүгээр зүйл.Тээвэрлэлтийн хөлс

61.1.Ачаа тээвэрлэлтийг зохион байгуулах гэрээнд өөрөөр заагаагүй бол ачаа илгээгч, тээвэр зуучлагч нь ачаа тээвэрлэлтийн хөлсийг ачааг илгээхээс өмнө төлнө. Энэ тохиолдолд ачааны тээвэрлэлтийн хөлсийг тээвэрлэлтийн хамгийн богино зайгаар тооцно.

61.2.Төмөр замын дэд бүтцийн техникийн боломж, нэвтрүүлэх чадварыг харгалзан овор хэмжээ ихтэй, хүнд жинтэй ачааг тээвэрлэх хамгийн богино зайг тодорхойлно.

61.3.Ачаа тээвэрлэлт, олголттой холбоотой эцсийн төлбөр тооцоог ачаа ирэх үед ачаа хүлээн авагч хийж дуусгана.

61.4.Ачаа илгээгч, хүлээн авагч, тээвэр зуучлагч нь ачаа тээвэрлэлтийн хөлсийг цаг тухайд нь төлж барагдуулаагүй бол хууль, гэрээнд өөрөөр заагаагүй тохиолдолд хөлс төлөх хүртэл дэд бүтэц эзэмшигч, тээвэрлэгч тээвэрлэлтийн дараагийн гэрээ байгуулахаас татгалзаж болно.

61.5.Тээвэрлэгч нь ачаа илгээгчийн төлбөл зохих тээвэрлэлтийн хөлс болон бусад төлбөрийг төлүүлэх зорилгоор түүний ачааг өөртөө үлдээж, саатуулах эрхтэй.

62 дугаар зүйл.Ачаа хүргэх хугацаа

62.1.Тээвэрлэгч нь ачаа тээвэрлэх дүрмийн дагуу тээвэрлэлтийн гэрээнд заасан хугацаанд ачааг төмөр замын хүрэх өртөөнд хүргэх үүрэгтэй.

62.2.Хэрэв ачаа хүргэх хугацаа дуусахаас өмнө ачаа хүрэх өртөөнд хүрч хүлээн авагчид хүлээлгэн өгсөн, эсхүл ачаа хүлээлцэх зам дээр тавигдсан бол уг ачааг хугацаанд нь хүргэсэн гэж үзнэ.

62.3.Ачаа илгээгч, ачаа хүлээн авагч, салбар зам эзэмшигчийн буруутай үйлдэл (ачаа буулгах зам эзэлгээтэй, ачаа тээвэрлэлттэй холбоотой хөлсийг бүрэн төлөөгүй)-ээс ачаа хүлээлцэх замд тавих ажил саатсан тохиолдолд уг ачааг хугацаанд нь хүргэсэн гэж тооцно.

63 дугаар зүйл.Ачааг олгох үед шалгалт хийх

63.1.Тээвэрлэгч ачааг олгох үед хийх шалгалтыг ачаа тээвэрлэх дүрмийн дагуу гүйцэтгэнэ.

63.2.Ачаа олгох үед ачааны жинг шалгахдаа ачааг ачих үед ачааны жинг тодорхойлсон аргыг хэрэглэнэ.

63.3.Явуулах өртөөнд жинлэсэн ачааг хүлээн авах өртөөнд жинлэхэд гарсан зөрүү нь ачаа тээвэрлэх дүрэмд заасан хэвийн хорогдлын болон жингийн зөрүүний нормоос хэтрээгүй бол ачааны жинг бүрэн гэж үзнэ.

64 дугаар зүйл.Ачаа гэмтсэн, дутагдсан хэмжээг тодорхойлох

64.1.Тээвэрлэж байгаа ачаа дутсан, гэмтсэн муудсан, алдагдсаныг илрүүлсэн тохиолдолд ачаа хүлээн авагч, тээвэрлэгч нар хамтран бодит хохирлын хэмжээг тодорхойлно.

64.2.Тээвэрлэгч, ачаа хүлээн авагчийн санаачлагаар ачааны бодит хохирлыг тодорхойлох шинжилгээ, судалгаа хийж болно.

64.3.Шинжилгээ болон судалгааны зардлыг буруутай этгээд хариуцна.

65 дугаар зүйл.Ачаа хүлээн авагч үүргээ зөрчсөний үр дагавар

65.1.Тээвэрлэгч нь ачаа хүлээн авагч ачааг хүлээн авах үүргээ гүйцэтгэхээс зайлсхийсэн тохиолдолд (түргэн муудах, аюултай ачаа 2 хоногийн дотор) тухайн ачаа ирсэн өдрөөс хойш 7 хоногийн дотор ачаа илгээгчид энэ тухай мэдэгдэж, ачааг хэрхэх тухай асуух үүрэгтэй.

65.2.Ачаа илгээгч уг мэдээг хүлээн авснаас хойш 4 хоногийн дотор (түргэн муудах, аюултай ачаа 2 хоногийн дотор) ачааг хэрхэх талаар шийдвэр гаргах үүрэгтэй.

65.3.Ачаа илгээгч түргэн муудах, гэмтэх ачааны талаар шийдвэр гаргаж, заавар ирүүлээгүй бөгөөд ачааг үргэлжлүүлэн хадгалах нь ачаа муудаж, гэмтэх нөхцөл үүсгэхээр бол тээвэрлэгч ачааг худалдах эрхтэй.

65.4.Тээвэрлэгч нь энэ хуулийн 68.1-т заасны дагуу түргэн муудаж, гэмтэх ачааг худалдсан орлогоос тээвэрлэлттэй холбоотой гаргасан зардлаа суутган авч илүү гарсан орлогыг ачаа илгээгчид олгоно.

65.5.Тээвэрлэгч нь энэ хуулийн 68.1-д заасны дагуу ачаа илгээгчээс ачааг хэрхэх талаар шийдвэр хүлээх явцад ачаа хүлээн авагч (ачааг хүлээн авахаас зайлсхийсэн) ачааг хүлээн авахаар хүсэлт гаргавал түүнд ачааг олгож болно.

65.6.Тээвэрлэгч ачаа хүлээн авагчаас ачааг захиран зарцуулах тухай шийдвэр хүлээн аваагүй нөхцөлд энэ хуульд заасны дагуу уг ачааг ачаа илгээгчийн зардлаар буцаах эрхтэй.

66 дүгээр зүйл.Өөр хүлээн авагчийн хаягаар ирсэн ачаа

66.1.Ачаа гэрээнд дурдаагүй ачаа хүлээн авагчийн хаягаар ирсэн, эсхүл төмөр замын тээврийн падаанд заасан ачаа хүлээн авагчийн нэртэй тохироогүй тохиолдолд ачаа илгээгч, хүлээн авагч, тээвэрлэгч нь дараах арга хэмжээг авна:

66.1.1.ачаа хүлээн авагч ачаа ирсэн тухай мэдэгдэл хүлээн авснаас хойш 1 хоногийн дотор тээвэрлэлтийн гэрээний дагуух хүлээн авагч биш гэдгээ бичгээр тээвэрлэгчид мэдэгдэх үүрэгтэй.

66.1.2.тээвэрлэгч ачааг хэрхэх талаар яаралтай шийдвэр гаргах тухай ачаа илгээгчид мэдэгдэнэ.

66.1.3.ачаа илгээгч 4 хоногийн дотор (түргэн муудах, аюултай ачаа 2 хоногийн дотор) ачааны талаар шийдвэр гаргаж, бичгээр мэдэгдэнэ.

66.2.Төмөр замын тээврийн падаанд нэр заагдсан ачаа хүлээн авагч тээвэрлэлттэй холбоотой хөлсийг бүрэн төлсөн тохиолдолд ачааг хүлээн авах эрхтэй.

66.3.Энэ хуулийн 69.1.3-т заасан хугацаанд ачаа хүлээн авагчаас ачааны талаар шийдвэр ирүүлээгүй тохиолдолд тээвэрлэгч тухайн ачааг ачаа хүлээн авагчийн зардлаар буцаах эрхтэй. Харин түргэн муудах, гэмтэх ачааг энэ хуулийн 68.3-т заасны дагуу худалдах эрхтэй.

67 дугаар зүйл.Ачаа тээвэрлэлтийн хүндрэл, саатал

67.1.Ачаа илгээгч, тээвэр зуучлагчийн үйл ажиллагаатай холбоотойгоор гааль, татвар болон бусад төрийн эрх бүхий байгууллага саатуулсны улмаас тээвэрлэлтэд саатал, хүндрэл үүссэн, ачааг өөр тээвэрлэгчид шилжүүлж цаашид тээвэрлэх боломжгүй болсон тохиолдолд тээвэрлэгч ачаа илгээгч, тээвэр зуучлагчид утсаар болон гэрээнд заасан бусад арга хэрэгслээр мэдэгдэх үүрэгтэй.

67.2.Хэрэв гэрээнд ачаа илгээгч, тээвэр зуучлагч нь энэ хуулийн 70.1-д заасан үүргийг хүлээсэн бол тухайн саатлын шалтгааныг тодруулж, шийдвэрлэх талаар арга хэмжээ авах үүрэгтэй.

67.3.Ачаа илгээгч, тээвэр зуучлагчийн буруугаас ачаа саатсан хугацаагаар тээвэрлэгчийн ачаа хүргэх хугацаа сунгагдана.

67.4.Экспорт, импортын ачааг саатуулсан хугацаанд тээвэрлэгчийн эзэмшлийн вагон, чингэлэг ашигласны хөлсийг буруутай этгээд тээвэрлэгчид төлөх ба дамжин өнгөрөх ачаа саатуулсан хугацаанд Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хэмжээгээр төлбөр төлнө.

67.5.Тээвэрлэгчээс мэдэгдэл хүлээн авснаас хойш ачаа илгээгч, ачаа хүлээн авагч саатсан ачааны талаар ажлын 8 хоногийн дотор (түргэн муудах, аюултай ачаа ажлын 4 хоногийн дотор) ямар нэгэн арга хэмжээ аваагүй бол тээвэрлэгч уг ачааг ачаа илгээгчийн зардлаар түүнд буцаах, ачааг вагон, чингэлгээс чөлөөлөхийг шаардах, түргэн муудах ачааг энэ хуулийн 68.3-т заасны дагуу худалдах эрхтэй.

68 дүгээр зүйл.Урьдчилсан мэдээлэл өгөх

68.1.Ачаа илгээгч, ачаа хүлээн авагч, тээвэр зуучлагч, гаалийн төлөөлөгч болон тээвэрлэлтэд оролцож байгаа бусад этгээд нь хууль, олон улсын гэрээнд заасны дагуу тогтоосон хугацаа, хэмжээгээр төрийн байгууллагад урьдчилан мэдэгдэхэд шаардагдах мэдээллийг тээвэрлэгчид өгөх үүрэгтэй.

69 дугаар зүйл.Тээвэрлэх үүргээ зөрчсөний хариуцлага

69.1.Тээвэрлэлтийн үед хэрэгжүүлэх үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд талууд Иргэний хууль, энэ хууль, холбогдох бусад хууль тогтоомж, олон улсын гэрээ, ачаа тээвэрлэх дүрэм, талуудын хооронд байгуулсан гэрээнд заасны дагуу хариуцлага хүлээнэ. Үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор

биелүүлээгүй талд хариуцлага хүлээлгэхдээ эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн талын шаардлагыг үндэслэнэ.

69.2.Энэ хуулиар тогтоосон хариуцлагыг тооцохгүй байх, хязгаарлах зорилго агуулсан талуудын хооронд байгуулсан гэрээг хүчин төгөлдөр бус гэж үзнэ. Талууд харилцан зөвшилцөж хариуцлагын хэмжээг нэмэгдүүлэх буюу тээвэрлэлтийн гэрээгээр нэмэлт хариуцлагыг хүлээж болно.

69.3.Тээвэрлэлтийн үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүйн төлөө үүсэх тээвэрлэгч хоорондын хариуцлагыг энэ хууль, ачаа, зорчигч тээвэрлэх дүрэм, тээвэрлэгч нарын хооронд байгуулсан гэрээгээр тодорхойлно.

69.4.Тээвэрлэлтийг хэд хэдэн тээвэрлэгч гүйцэтгэсэн тохиолдолд тэдгээр нь ачаа илгээгч эсхүл ачаа хүлээн авагчийн өмнө ачаа, тээш, ачаан тээшийг үрэгдүүлсэн, дутаасан, гэмтээж муутгасан болон хүргэх хугацааг нь хожимдуулсны төлөө хамтын хариуцлага хүлээнэ.

69.5.Хэрэв өөр тээвэрлэгч, ачаа илгээгч, хүлээн авагч, салбар зам эзэмшигч, тээвэр зуучлагчийн буруугаас үүссэн хариуцлагыг тээвэрлэгч хүлээсэн бол хохирлоо буруутай этгээдээс шаардах эрхтэй.

70 дугаар зүйл.Торгууль

70.1.Ачаа тээвэрлэх үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүй буруутай тал хууль болон гэрээнд өөрөөр заагаагүй бол торгууль төлнө.

70.2.Тээвэрлэгчид хөлс төлөх хугацаа хоцроосон тохиолдолд хууль болон гэрээнд өөрөөр заагаагүй бол торгууль төлнө.

70.3.Хууль болон талуудын хооронд байгуулсан гэрээнд өөрөө заагаагүй бол төлөгдсөн төлбөрийн нийт дүнгээс эхний ээлжинд торгуулийг төлж барагдуулна.

70.4.Энэ хуулийн 73.1, 73.2, 77.2, 78.1, 78.2, 78.3, 79.1, 79.3, 80.1, 81.1, 84.1-д заасан торгуулийн хэмжээг талуудын хооронд байгуулсан гэрээгээр тогтооно.

71 дүгээр зүйл.Зорчигчийн амь нас, эрүүл мэндэд хохирол учирсан үед тээвэрлэгчид үүсэх хариуцлага

71.1.Тээвэрлэгч зорчигчийн амь нас, эрүүл мэндэд хохирол учруулснаас үүсэх хариуцлагыг хуульд заасны дагуу хүлээнэ.

71.2.Зорчигч галт тэргэнд суух, буух, галт тэргэнд зорчиж явах, зорчигчид үйлчлэх цогцолборын нутаг дэвсгэрт байх үед, түүний амь нас, эрүүл мэндэд учирсан хохирлыг тээвэрлэгч хариуцна.

72 дугаар зүйл. Ачаа, тээш, ачаан тээш алдсан, дутаасан, муутгаж гэмтээсэн тохиолдолд тээвэрлэгчийн хүлээх хариуцлага

72.1.Тээвэрлэгч нь ачаа, ачаан тээш, тээшийг тээвэрлэлтэд хүлээн авсан мөчөөс хүлээн авагчид олгох үе хүртэл түүний бүрэн бүтэн байдлыг хангах үүрэгтэй.

72.2.Ачаа, ачаан тээш, тээш алдсан, дутаасан, муутгаж гэмтээсний эд хөрөнгийн хариуцлага тэдгээрийг тээвэрлэлтэд хүлээн авсан мөчөөс тээвэрлэгчид шилжинэ.

72.3. Үнэ зарлалгүйгээр тээвэрлэлтэд хүлээн авсан ачааг алдаж үрэгдүүлсэн, дутаасан, гэмтээж муутгасны хариуцлагыг тээвэрлэгч дор дурдсан хэмжээгээр хариуцна. Үүнд:

72.3.1. алдаж үрэгдүүлж, дутаасан бол алдаж үрэгдүүлж, дутаасан ачааны өртгийн хэмжээгээр;

72.3.2. гэмтээж, муутгасан бол ачааны өртөг буурсан үнийн дүнгийн хэмжээгээр;

72.3.3. ачааны өртгийг тодорхойлохдоо худалдаж авсныг нотлох баримт, эсхүл харьцуулж болохуйц, ижил төрлийн барааны жишиг үнийг тус тус үндэслэл болгоно.

72.4. Үнэ зарлаж тээвэрлэлтэд хүлээн авсан ачаа, ачаан тээш, тээшийг алдаж үрэгдүүлсэн, дутаасан, гэмтээж муутгасан бол тээвэрлэгч зарласан үнийн хэмжээгээр хариуцлага хүлээнэ.

72.5. Тээвэрлэгч нь энэ хуулийн 75.3, 75.4-т заасан хохирлыг нөхөн төлснөөс гадна алдсан, дутаасан, муутгаж гэмтээсэн ачааг тээвэрлэхэд авсан тээврийн хөлсийг (хэрэв тээврийн хөлс нь тэдгээр ачааны үнэд багтаагүй бол) тээвэрлэгч ачаа илгээгч (ачаа хүлээн авагч)-д буцаан төлнө.

72.6. Хүргэх хугацаа дуусаад 7 хоног өнгөрсөн бол ачаа, ачаан тээш, тээшийг алдагдсан гэж тооцно. Заасан хугацаа дуусахад ачаа, тээш, ачаан тээш ирсэн тохиолдолд хүлээн авагч нь тэдгээрийг хүлээн авч, ачаа алдаж үрэгдүүлсний төлөө тээвэрлэгчээс төлсөн төлбөрийг буцаана.

72.7. Ачаа, ачаан тээш, тээш алга болсон, дутсан, гэмтэж муудсан нь тээвэрлэгч буруугүй болохоо нотолж чадахгүй бол тээвэрлэгч холбогдох хариуцлага хүлээнэ.

72.8. Төмөр замын тээврийн падаанд заасан мэдээлэлтэй тохирохгүй ачааг олгосон бол (уг ачааг тээвэрлэгч ачсан) тээвэрлэгч ачааг алдсаны нэгэн адил ачааны өртгийн хэмжээгээр хариуцлага хүлээнэ.

73 дугаар зүйл. Ачаа тээвэрлэлтийн төлөвлөгөөний захиалгыг биелүүлээгүйн хариуцлага

73.1. Тээвэрлэгч нь хүлээн авсан захиалгын дагуу вагон, чингэлэг тавьж өгөөгүйн, ачаа илгээгч ачааг тээвэрлэлтэд өгөөгүйн болон өгсөн вагон, чингэлгийг ашиглаагүйн эд хөрөнгийн хариуцлагыг харилцан хүлээнэ. Хариуцлагын хэмжээг ачаа тээвэрлэлтийн дүрмээр тогтооно.

73.2. Ачаа тээвэрлэлтийн төлөвлөгөөний захиалгыг биелүүлээгүйн торгуулийг вагон, чингэлэг ашигласны төлбөрөөс үл хамааруулан суутгаж авна.

74 дугаар зүйл. Вагон, чингэлгийг дур мэдэн ашигласан, гэмтээсэн, алдагдуулсны хариуцлага

74.1. Тээвэрлэгч, ачаа илгээгч, ачаа хүлээн авагч нь (хэрэв зохих гэрээнд заагаагүй бол) бусдын эзэмшлийн вагон, чингэлгийг түүний эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр тээвэрт ашиглах, ачилтад авах эрхгүй.

74.2. Хууль болон гэрээнд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 77.1-д заасан шаардлагыг биелүүлээгүй буруутай тал вагон, чингэлэг ашигласны хөлснөөс гадна торгууль төлнө.

75 дугаар зүйл. Ачаа хүргэх хугацаа зөрчсөний хариуцлага

75.1. Ачаа хүргэх хугацааг Ачаа тээвэрлэх дүрмийн дагуу тооцно.

75.2. Ачаа хүргэх хугацаа хожимдуулсан тохиолдолд тээвэрлэгч нь (өөрийн буруугаас болоогүй гэдгээ нотолж чадаагүй бол) ачаа хүлээн авагчид торгууль төлнө.

75.3. Тээвэрлэгч нь бусдын эзэмшлийн хоосон вагоныг хүргэх хугацааг хожимдуулсан бол торгууль төлнө.

75.4. Экспорт, импорт, шууд дамжин өнгөрөх ачааны баримт бичиг бүрдүүлэх талаарх Монгол Улсын хууль тогтоомжийн шаардлагыг ачаа илгээгч, ачаа хүлээн авагч, тээвэр зуучлагч зөрчсөнөөс вагон, чингэлэг саатсан бол тээвэрлэгч буруутай этгээдээс вагон, чингэлэг ашиглалтын хөлс, торгууль шаардах эрхтэй.

76 дүгээр зүйл. Зорчигч, тээш, ачаан тээшийн хүргэх хугацааг зөрчсөний хариуцлага

76.1. Тээш, ачаан тээш хүргэх хугацаа хожимдуулсан тохиолдолд тээвэрлэгч нь (өөрийн буруугаас болоогүй гэдгээ нотолж чадаагүй бол) зорчигчид торгууль төлнө. Хүргэх хугацаа хожимдуулсан хугацааг тээш, ачаан тээш ирэх ёстой хоногийн 24.00 цагаас тоолж эхэлнэ.

76.2. Тээш, ачаан тээш хүргэх хугацаа зөрчсөний торгуулийг зорчигч тээвэрлэлтийн дүрэмд заасны дагуу тээш, ачаа тээшийг хүлээн авагч, зорчигчийн гаргасан өргөдлийн дагуу эрх бүхий этгээдээс тогтоосон актын дагуу төлнө.

76.3. Давагдашгүй хүчин зүйлийн нөлөөллөөс бусад тохиолдолд зорчигч тээвэрлэж байгаа зорчигчийн галт тэрэг явах өртөөнөөс хоцорч явсан, хүрэх өртөөнд хоцорч ирсэн тохиолдолд тээвэрлэгч нь (өөрийн буруугаас болоогүй гэдгээ нотолж чадаагүй бол) зорчигчид торгууль төлнө. Зорчигчийн галт тэрэг хоцроосны торгуулийг зорчигч тээвэрлэлтийн дүрэмд заасны дагуу зорчигч өргөдлийг үндэслэл болгоно.

77 дугаар зүйл. Тээвэрлэлтийн нөхцөлийг зөрчиж ачаа, ачаан тээш, тээшийг тээвэрлэлтэд өгсний хариуцлага

77.1. Төмөр замын тээврийн падаанд ачааны нэр болон онцлог шинж чанар, болгоомжлох шаардлагатай арга хэмжээг буруу заасан, тээвэрлэхийг хориглосон ачаа явуулсан бол ачаа илгээгч нь тээвэрлэгчид торгууль төлнө.

77.2. Тээш, ачаан тээшийг илгээгч нь Монгол Улсын хууль тогтоомжид зааснаар тээвэрлэхийг хориглосон ачаа тээвэрлэсэн (тээвэрлэхийг оролдсон) бол хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээнэ.

77.3.Ачаа илгээгч нь вагон, чингэлэгт ачаа ачихдаа Монгол Улсын хуулиар хориглосон ачаа ачсан, ачаанд нуусан бол холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээнэ.

78 дүгээр зүйл.Вагон, чингэлгийн даац хэтрүүлсний хариуцлага

78.1.Ачаа илгээгч нь вагон чингэлгийн даац (багтаамж)-ыг хэтрүүлэн ачсан бол тээвэрлэгчид торгууль төлнө. Ачаа илгээгч вагон, чингэлгийн даац хэтрүүлснээс үүдэж учирсан хохирлыг тээвэрлэгчид нөхөн төлнө.

79 дугаар зүйл.Ачаа буулгалтын дараах вагон, чингэлгийн цэвэрлэгээ

79.1.Ачаа хүлээн авагч нь ачаагаа буулгасны дараа вагон, чингэлгийг цэвэрлэж, тээвэрлэгчид хүлээлгэн өгөх үүрэгтэй.

79.2.Тээвэрлэгч нь цэвэрлээгүй вагон, чингэлгийг хүлээн авахаас татгалзах эрхтэй.

79.3.Ачаа хүлээн авагч вагон, чингэлгийг цэвэрлэхээс татгалзсан тохиолдолд вагон, чингэлгийг цэвэрлэх газарт хүргэсэн зардал болон цэвэрлэгээний хөлсийг ачаа хүлээн авагч нь тээвэрлэгчид төлөх үүрэг хүлээнэ.

79.4.Вагон, чингэлгийг цэвэрлэхээр зогсоосон хугацаанд ачаа хүлээн авагч тээвэрлэгчид ачаа тээвэрлэлтийн дүрэмд заасны дагуу вагон, чингэлэг ашигласны хөлс төлнө.

80 дугаар зүйл.Хөдлөх бүрэлдэхүүн, чингэлэг, авагддаг тоноглол

80.1.Хөдлөх бүрэлдэхүүн, чингэлэг, авагддаг тоноглол, баглаж боох хэрэгслийг гэмтээсэн, үрэгдүүлсэн буруутай этгээд нь ачаа тээвэрлэлтийн дүрэмд заасны дагуу тэдгээрийн эзэмшигч (өмчлөгч)–д тухайн эд хөрөнгийн үнэ, засварын зардлыг төлнө.

81 дүгээр зүйл.Салбар замд вагон тавьж өгөөгүй, татаж аваагүй саатуулсны хариуцлага.

81.1.Салбар зам ашиглах, вагон тавьж өгөх, татаж авах гэрээнд зааснаар тээвэрлэгч нь салбар замын ачилт буулгалтын газарт вагон тавих, татах, хүлээн авах ажлыг саатуулсан тохиолдолд торгууль төлнө.

82 дугаар зүйл.Хариуцлагаас чөлөөлөгдөх

82.1.Тээвэрлэлтийн гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүйн хариуцлагаас Иргэний хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, хэлэлцээрт заасан үндэслэлээр гэрээний талуудыг чөлөөлнө.

82.2.Дор дурдсан нөхцөл шалтгааны улмаас үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүй бол талуудыг хариуцлагаас чөлөөлнө.Үүнд:

82.2.1.давагдашгүй хүчин зүйл, байгалийн, техногены шинж чанартай онцгой байдал;

82.2.2.цэрэг дайны ажиллагаа онц байдал тогтоосон;

82.2.3.энэ хуулиар тогтоосон журмаар зарласан галт тэрэгний хөдөлгөөн, ачаа шилжүүлэх үйл явцыг хязгаарласан, хориглосон.

83 дугаар зүйл.Тээвэрлэгч хариуцлагаас чөлөөлөгдөх

83.1.Тээвэрлэгч нь дор дурдсан тохиолдолд хариуцлагаас чөлөөлөгдөнө.
Үүнд:

83.1.1.зорчигч, ачаа илгээгч, ачаа хүлээн авагч, тээвэр зуучлагчийн буруугаар үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүй;

83.1.2.ачаа илгээгчтэй зөвшилцсөн 10 хоногийн хугацаанд, 10 хоногийн тодорхой өдрүүдэд зөвшөөрөгдсөн дутуу тавилтыг нөхөн хийсэн;

83.1.3.энэ хуульд заасан үндэслэлээр ачаа явуулахыг саатуулсан, вагон чингэлгээр хангахыг хориглосон;

83.1.4.ачаа хүлээн авагч ачаагаа цаг тухайд буулгаагүй, зөөж тээвэрлээгүйн улмаас ачаа муудаж гэмтсэн;

83.1.5.ачаа, ачаан тээш, тээш гэмтэлгүй вагон, чингэлэгт (ачаа илгээгчийн тавьсан гэмтэлгүй ломботой) ирсэн, замдаа шилжүүлэн ачилт хийгдээгүй, гэмтэлгүй хөдлөх бүрэлдэхүүнд, гэмтэлгүй хамгаалалтын тэмдэг, тэмдэглэгээ, гэмтэлгүй бэхэлгээтэй ирсэн, түүнчлэн ачаа, ачаан тээш, тээшийн бүрэн бүтэн гэдгийг нотлох бусад шинж тэмдэг байгаа тохиолдолд;

83.1.6.ачааг хадгалах тээвэрлэх үед ачааны өөрийн шинж байдал, баримтлах, болгоомжлох арга хэмжээ, онцгой нөхцөл шаардсан онцлог чанарыг тээвэрлэлтийн бичиг баримтад заахгүйгээр тээвэрлэлтэд өгсний улмаас ачааны бүрэн бүтэн байдал алдагдсан;

83.1.7.ачааг битүү вагон, чингэлэгт ачсан, ачилт буулгалтыг ачаа илгээгч, ачаа хүлээн авагчийн хүч хэрэгслээр хийж гүйцэтгэсэн;

83.1.8.задгай хөдлөх бүрэлдэхүүнд тээвэрлэх үед байгаль цаг уурын нөлөөллийн улмаас ачааны бүрэн бүтэн байдал алдагдсан;

83.1.9.ачааг ачаа илгээгчийн болон ачаа хүлээн авагчийн хүргэгч дагалдсан;

83.1.10.ачаа илгээгч төмөр замын тээврийн падаанд заасан мэдээллийг буруу, хагас дутуу, бүрэн зөв бичээгүй;

83.1.11.тээвэрлэгчийн оролцоогүйгээр ачаа илгээгч жинлэж тодорхойлон тээвэрлэлтэд хүлээн авсан ачааны жин зөрүүтэй, хэвийн хорогдлын норм, чийгшлийн бууралт зэрэг нь ачааны жин дутсанд хүлээх хариуцлагын хувиас хэтрээгүй, жингийн заалтуудын норм зөрүүтэй;

83.1.12.тээвэрлэлтийн температурын горим, ачаа хүргэх хугацаа зөрчигдөөгүй боловч хялбар муудах ачаа муудаж, гэмтсэн;

83.1.13.тээвэрлэлтийн сав баглаа, боодлын далд гэмтэл, дутагдал, эсхүл тэдгээрийн далд шинж чанарын улмаас ачаа, ачаан тээш, тээшийн бүрэн бүтэн байдал алдагдсан;

83.1.14. ачаа илгээгч тухайн ачааг тээвэрлэхэд тохирохгүй вагон болон чингэлэгт ачааг ачсан;

83.1.15. ачаа илгээгч хялбар муудах ачааны тээвэрлэлтийн буруу арга хэрэглэсэн ба вагон (чингэлэг)-ы төрлийг буруу сонгосон;

83.1.16. төрийн байгууллагууд тээвэрлэгчээс үл хамаарах шалтгаанаар ачаа, ачаа тээш, тээшийг шалгасан, саатуулсан, эсвэл хураасан.

83.2. Тээвэрлэгчийн буруугаас тээш гэмтэх тохиолдлоос бусад үед тээвэрлэгч зорчигчийн гар тээш, зорчигчтой хамт яваа тээшийн бүрэн бүтэн байдлын хариуцахгүй.

84 дугаар зүйл. Ачаа илгээгч, ачаа хүлээн авагч хариуцлагаас чөлөөлөгдөх

84.1. Ачаа илгээгч, ачаа хүлээн авагч дор дурдсан тохиолдолд хариуцлагаас чөлөөлөгдөнө. Үүнд:

84.1.1. ачаа илгээгч, хүлээн авагчтай урьдчилан тохиролцолгүй тавьж өгсөн вагон, чингэлгийг ашиглаагүй бол;

84.1.2. тээвэрлэгчтэй зөвшилцсөн хуанлийн 10 хоногийн хугацаанд, 10 хоногийн тодорхой өдрүүдэд зөвшөөрөгдсөн ачилтын дутууг нөхсөн;

84.1.3. ачилтын хэмжээг нягтруулснаар захиалгад зааснаас цөөн тооны вагон, чингэлэг ашигласан;

84.1.4. ачилт эхлэхээс 3-аас багагүй хоногийн өмнө вагон, чингэлгийг ашиглахгүй тухай тээвэрлэгчид урьдчилан мэдэгдсэн.

85 дугаар зүйл. Акт, гомдол, нэхэмжлэл гаргах нөхцөл журам

85.1. Тээвэрлэлтийн гэрээнээс үүссэн гомдлыг зорчигч, илгээгч (ачаа илгээгч), хүлээн авагч (ачаа хүлээн авагч) тээвэрлэгчид гаргах эрхтэй.

85.2. Вагон, чингэлгийг алдсан, гэмтээсэн тохиолдолд вагон, чингэлгийн өмчлөгч болон эзэмшигч нь тээвэрлэгчид гомдол гаргах эрхтэй.

85.3. Тээвэрлэлтийн гэрээгээр харилцан тохиролцсон тохиолдолд иргэн, хуулийн этгээд нь энэ хуульд заасан гомдол гаргах эрхтэй этгээдийн нэрийн өмнөөс тээвэрлэгчид гомдол гаргах эрхтэй.

85.4. Гомдол гаргагч нь гомдолд гомдол гаргах эрхтэйг нотолсон баримтыг хавсаргасан байна.

85.5. Дор дурдсан тохиолдолд гомдол гаргагч нь гомдлын шаардлагыг нотлох дараах баримт бичгийг эх хувиар гомдолд хавсаргана:

85.5.1. зорчигчийн амь нас, эрүүл мэндэд учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шаардсан бол:

85.5.1.1. зорчих тасалбар;

85.5.1.2. ослын акт.

85.5.2. зорчигчийн галт тэрэг цагтаа яваагүй, хоцорсон үед зорчсон үнийг буцаах шаардлага гаргасан бол:

85.5.2.1. зорчих тасалбар;

85.5.3. тээш, ачаа тээш алдагдсан, хүргэх хугацаа хэтрүүлснээс ачаа, ачаан тээш, тээшийн тээврийн хөлсийг буцаах шаардлага гаргасан бол

85.5.3.1. тээш, ачаан тээшийн төлбөрийн баримт;

85.5.4. тээш, ачаан тээш дутсан, гэмтсэн (муудсан) бол:

85.5.4.1. тээш, ачаан тээшийн төлбөрийн баримт ба тээврийн акт;

85.5.5. зорчигч, тээш, ачаан тээшийн тээврийн хөлсийг буруу бодсон, тээш, ачаан тээшийн жинг буруу тодорхойлсон, тээврийн хөлсийг буруу тооцоолсон бол:

85.5.5.1. зорчих тасалбар, тээш, ачаан тээшийн төлбөрийн баримт;

85.5.6. ачаа бүрэн алдагдсан бол:

85.5.6.1. ачаа хүрэх өртөөнд хүлээн авагч тээврийн падааны “Ачаа олгосон тухай тэмдэглэл” хүснэгтэнд ачаа ирээгүй тухай тэмдэглэлийг тээвэрлэгч хийсэн падаан, тээвэрлэгчийн тогтоосон тээврийн акт, ачааны үнэ болон тоо ширхэгийг баталсан үнийн баримт;

85.5.7. ачаа дутсан, гэмтсэн (муудсан) бол:

85.5.7.1. төмөр замын тээврийн падаан, хүрэх өртөөнд өгсөн тээврийн акт, дутсан, гэмтсэн (муудсан) ачааны тоо ширхэг, үнийг баталсан ачаа бараа нийлүүлэгчтэй хийсэн гэрээ, төлбөрийн бичиг баримт.

85.5.8. ачааг олгох үед ачаа гэмтэж, муудсанаас ачааны үнэ болон сорт буурсан бол гомдолд магадлан шинжилгээний актыг хавсаргана.

85.5.9. ачаа хүргэх хугацааг хэтрүүлсэн бол:

85.5.9.1. төмөр замын тээврийн падаан;

85.5.10. илүү төлөлт хийсэн бол:

85.5.10.1. төмөр замын тээврийн падаан;

85.5.10.2. төлбөр төлснийг нотолсон бичиг баримт;

85.5.11. тээврийг гүйцэтгээгүй бол:

85.5.11.1. ачааг буцаасан тээвэрлэгчийн тэмдэглэл бүхий ачааг тээвэрт хүлээн авсан орлох падаан;

85.5.12. ачааг тээвэрлэхтэй холбоотой хураамж ба торгуулийг илүү төлсөн бол:

85.5.12.1. тээврийн падаан, төлбөрийн бичиг баримт;

85.5.13.иргэн, хуулийн этгээдийн эзэмшлийн вагон, чингэлгийг тээвэрлэгч алдсан, гэмтээсэн бол:

85.5.13.1. тээвэрт хүлээн авсан падаан (хүрэх өртөөнд вагон, чингэлэг ирээгүй тухай тээвэрлэгчийн тэмдэглэл бүхий), тээвэрлэгчийн тогтоосон акт;

85.5.13.2. техникийн паспорт, эзэмшигч буюу түрээслэгчийг баталсан бичиг баримт.

85.6.Энэ хуулийн 88.5-д заасан тохиолдлуудад тус тусад нь гомдол гаргана.

85.7.Ачаа алдагдсан, дутсан, гэмтсэн, муудсаныг нэхэмжилсэн гомдлыг илгээлт тус бүрээр гаргана.

85.8.Нэг төрлийн ачааг нэг илгээх өртөөнөөс нэг ачаа илгээгч ачсан нэг хүрэх өртөө, нэг хүлээн авагчтайгаар тээвэрлэлтийг гүйцэтгэж, тээвэрлэгч 1 тээврийн акт үйлдсэн бол бүлэг ачаа илгээлтэд 1 гомдол гаргаж болно.

85.9.Замналаар болон бүлэг илгээлтээр явж байгаа ачаанд тээврийн актад заагдсан вагоны тоогоор гомдлыг гаргана.

85.10.Нэг өдөр ирсэн хэд хэдэн илгээлтийн ачаа хүргэх хугацаа хэтэрсэн тохиолдолд хамтатган нэг гомдол гаргаж болно.

86 дүгээр зүйл.Гомдлын мэдүүлгийн иж бүрдэл

86.1.Гомдолд дараах зүйлийг заана.

86.1.1.овог, нэр эсхүл гомдол гаргагч байгууллагын нэр, шуудангийн хаяг, гомдол гаргасан огноо;

86.1.2.гомдол гаргах болсон шалтгаан, нөхцөл;

86.1.3.гомдол гаргагчийн шаардлага, нэхэмжлэлийн хэмжээ ба тооцоо, банкны мэдээлэл;

86.1.4.гомдолд хавсаргасан бичиг баримтын жагсаалт, бусад нотолгоо.

86.2.Иргэний гаргасан гомдолд гомдол гаргагч гарын үсэг зурж, биеийн байцаалтыг нотолсон бичиг баримтын хуулбарыг хавсаргана.

86.3.Хуулийн этгээд гомдол гаргасан тохиолдолд байгууллагын дарга болон эсхүл эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулна.

86.4.Ачааг хүлээн авсан бичиг баримтыг илгээгчид өгсөн, падаан нь хүлээн авагчид цахим хэлбэрээр ирсэн тохиолдолд гомдол гаргагч нь илгээлтийн дугаар, ачааг тээвэрт хүлээн авсан огноо, тээвэрлэгчийн цахим мэдээллийн бүртгэлийн дугаарыг заана.

87 дүгээр зүйл.Гомдол гаргах хугацаа

87.1.Тээврийн гэрээнээс үүдэлтэй гомдлыг гомдол гаргах хөөн хэлэлцэх хугацаанд тээвэрлэгчид гаргана.

87.2.Гомдолыг дараах хугацаанд гаргана:

87.2.1.ачаа, ачаан тээш, тээш үрэгдсэн нөхөн олговрын гомдлыг ачаа хүргэх хугацаа хэтэрснээс хойш хуанлийн 10 хоногийн дотор;

87.2.2.ачаа, ачаан тээш, тээш дутсан, гэмтсэн (муудсан), хүргэх хугацаа хэтэрсэн нөхөн олговрыг ачаа, ачаан тээш, тээшийг олгосон өдрөөс;

87.2.3.ачаа, ачаан тээш, тээшийг тээвэрлэхэд илүү төлсөн тээврийн хөлсийг буцаахад эдгээрийг олгосон өдрөөс;

87.2.4.тээш ба ачаан тээшийн хүргэх хугацааг хэтрүүлсэн тохиолдолд олгох өдрөөс;

87.2.5.ачаа тээвэрлэх захиалгыг биелүүлээгүйн торгуулийг ногдуулах тохиолдолд ачаа тээврийн дүрэмд захиалгыг биелүүлэхээр заасан хугацаа дуусгавар болмогц;

87.2.6.бусад тохиолдолд шаардлага гаргах үндэслэл болох нөхцөл бий болсон өдрөөс гомдол гаргана.

87.3.Гомдол гаргасан өдрийг гомдлыг шуудангаар илгээсэн өдрөөр, тээвэрлэгчид хүргэж өгсөн өдрөөс тооцно.

87.4.Хэрвээ гомдол гаргах сүүлийн өдөр ажлын бус өдөр таарвал гомдол өгөх хугацаа дууссан өдрийн дараагийн ажлын өдрөөр тооцно.

88 дүгээр зүйл.Гомдол судлах хугацаа, журам

88.1.Тээвэрлэгч гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш 2 сарын хугацаанд судална.

88.2.Тээвэрлэгч гомдлыг хүлээж авахдаа дараах зүйлийг шалгана:

88.2.1.гомдол гаргах этгээдийг зөв тодорхойлсон эсэх;

88.2.2.гомдол мэдүүлэх эрх, итгэмжлэл байгаа эсэх;

88.2.3.гомдол мэдүүлэх хугацааг баримталсан эсэх;

88.2.4.гомдолд хавсаргасан бичиг баримтын бүрдэлт бүрэн эсэх;

88.2.5.гомдолд хавсаргасан бичиг баримтын эх хувь байгаа эсэх;

88.2.6.гомдол гаргасан бичиг баримт нь буруутай этгээдэд эд материалын хариуцлага хүлээлгэх үндэслэл болон хохирлын хэмжээг нотлох баримт болох эсэх.

88.3.Гомдлыг судалсан тухай гомдол гаргагчид бичгээр мэдэгдэх бөгөөд дараах зүйлийг тусгана:

88.3.1.гомдлын хариуг авах гомдол гаргагчийн овог, нэр эсхүл байгууллагын нэр, шуудангийн хаяг, гомдлын хариу өгч байгаа огноо;

88.3.2.гомдлыг хэсэгчлэн буюу бүрэн зөвшөөрсөн тохиолдолд хүлээн зөвшөөрсөн дүн, гомдлыг барагдуулах арга;

88.3.3.гомдлыг хэсэгчлэн буюу бүрэн татгалзсан тохиолдолд татгалзсан үндэслэл шалтгааныг нотлох холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын үндэслэлийг заах;

88.3.4.хавсаргасан баримт бичгийн жагсаалт.

88.4.Гомдлыг бүрэн барагдуулсан тохиолдолд тээвэрлэгч гомдол гаргагчийн ирүүлсэн баримт бичгийг буцаахгүй.

88.5.Гомдлоос бүрэн буюу хэсэгчлэн татгалзсан тохиолдолд гомдол гаргагчид гомдолтой цуг ирүүлсэн баримт бичгийг буцаана.

88.6.Хэрвээ гомдлоос татгалзах үндэслэл болсон баримт бичиг гомдол гаргагчид байхгүй бол уг баримт бичгийг түүнд илгээнэ.

88.7.Энэ хуульд заасан бүрдүүлбэрийг хангаагүй гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш хуанлийн 10 хоногийн дотор шалтгааныг зааж гомдол гаргагчид буцаана. Гомдлыг буцаах нь гомдлыг барагдуулахаас татгалзах үндэслэл болохгүй.

88.8.Ачааг алдсан, гэмтсэн нөхөн төлбөрт төлөх үнийг худалдаж авсныг нотлох баримт, эсхүл гэрээнд заасан үнийг үндэслэн тодорхойлно. Гэрээнд үнэ заагаагүй, худалдаж авсныг нотлох баримтгүй тохиолдолд харьцуулж болохуйц, ижил төрлийн барааны жишиг үнээр тооцоолно.

88.9.Хэрэв ачааны үнийн дүнд алдагдсан, дутсан, муудсан буюу гэмтсэн ачааны тээвэрлэлтийн хөлс ороогүй бол тээвэрлэлтийн хөлсийг бусад нөхөн төлбөрийн хамт буцааж төлнө.

88.10.Хэрвээ ачааг үнэ зарлаж тээвэрт хүлээлгэн өгсөн бол ачаа алдагдсан тохиолдолд тээвэрлэгч зарласан үнийн хэмжээгээр төлбөр төлнө. Ачааны зарим хэсэг алдагдсан бол алдагдсан хэсэгт ногдох зарласан үнийн хувь хэмжээгээр төлбөр төлнө.

88.11.Хэрэв гомдлыг судлах явцад ачааны хаяг солигдсон, эсхүл ачаа илгээгч болон анхны ачаа хүлээн авагчийн хүсэлтээр өөр хүлээн авагчид олгосон нь тогтоогдвол гомдлыг гомдол гаргагчид буцаана. Гомдлыг буцаахдаа ачааг авсан ачаа хүлээн авагч, эсхүл ачаа олгох хаяг солиулах өргөдөл гаргасан этгээдийн нэрийг заасан байна.

88.12.Олон улсын харилцаанд Олон улсын төмөр замын ачааны харилцааны хэлэлцээр, Олон улсын төмөр замын зорчигчийн харилцааны хэлэлцээрийн дагуу гомдлыг судална.

89 дугаар зүйл.Акт

89.1.Тээвэрлэлтийн явцад тээвэрлэгч, илгээгч (ачаа илгээгч), хүлээн авагч (ачаа хүлээн авагч), тээвэр зуучлагч, зорчигчдод эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэх нөхцөл, байдлыг тээвэрлэгчийн тогтоосон тээврийн актаар баталгаажуулна.

89.2.Тээврийн актын загвар, тэдгээрийг үйлдэх зааврыг Ачаа тээврийн дүрмээр тогтооно.

89.2.1.ачаа, ачаан тээш, тээшийг олгох үед дор дурдсан нөхцөл, байдлыг баталгаажуулах зорилгоор тээвэрлэгч тээврийн акт тогтооно. Үүнд:

89.2.1.1. тээвэрлэлтийн бичиг баримтад заасан жин, байрын тоо, нэр зөрсөн;

89.2.1.2. гэмтсэн, муудсан;

89.2.1.3. бичиг баримтгүй ачаа, ачаан тээш, тээш илэрсэн;

89.2.1.4. ачаа, ачаан тээш, тээшгүй тээвэрлэлтийн бичиг баримт илэрсэн;

89.2.1.5. хулгайлагдсан ачаа, ачаан тээш, тээшийг тээвэрлэгчид буцаан өгсөн;

89.2.1.6. ачаа олгох бичиг баримт үйлдсэнээс хойш 24 цагийн дотор тээвэрлэгч ачааг буулгалтын замд тавиагүй тохиолдолд зөвхөн ачаа хүлээн авагчийн шаардлагаар;

89.2.1.7. ачаа, ачаан тээш, тээшийг худалдах болсон.

89.3.Тээвэрлэгч тээвэрлэлтийн бичиг баримтад тээврийн акт тогтоосон тэмдэглэгээг заавал хийх үүрэгтэй.

89.4.Энэ хуулийн 92.2-т зааснаас бусад нөхцөл, байдлыг баталгаажуулахад ерөнхий маягтын акт тогтооно.

89.5.Акт тогтооход оролцсон талууд актад гарын үсэг зурахаас татгалзах эрхгүй.

89.6.Актад заасныг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд талууд өөрийн саналыг тусгах эрхтэй.

89.7.Бодит байдалд нийцээгүй мэдээлэл агуулсан акт үйлдсэн болон гарын үсэг зурсан этгээд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

90 дугаар зүйл.Нэхэмжлэл гаргах

90.1.Гомдлыг хүлээн авахаас бүрэн болон хэсэгчлэн татгалзсан, эсхүл гомдлыг судлах хугацаанд тээвэрлэгч хариу өгөөгүй бол тээвэрлэгчид холбогдуулан шүүхэд нэхэмжлэл гаргаж болно.

Гуравдугаар дэд бүлэг.Тусгай тээвэрлэлт

91 дүгээр зүйл.Тусгай тээвэрлэлт

91.1.Төмөр замын дэд бүтэц эзэмшигчийн болон хөдөлгөөний нэгдсэн зурмагт тусгагдаагүй, ачаа, зорчигч тээврийн дүрмээр зохицуулагдаагүй тусгай тээвэрлэлтийг төрийн болон холбогдох байгууллагын захиалгаар гэрээний үндсэн дээр гүйцэтгэнэ.

91.2.Тусгай тээвэрлэлттэй холбоотой харилцааг Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эрх бүхий байгууллагатай зөвшилцөн баталсан журмаар зохицуулна.

92 дугаар зүйл.Цэргийн тээвэрлэлт

92.1.Цэргийн тээвэрлэлт гүйцэтгэхтэй холбоотой харилцааг Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эрх бүхий байгууллагатай зөвшилцөн баталсан тусгай журмаар зохицуулна.

93 дугаар зүйл.Байнгын ашиглалтад хүлээж аваагүй төмөр замын дэд бүтцээр хийх тээвэрлэлт

93.1.Байнгын ашиглалтад хүлээж аваагүй, баригдаж байгаа төмөр замын шугамаар хийх тээвэрлэлтийг төмөр замыг барьж санхүүжүүлж байгаа байгууллагатай гэрээ хийсний үндсэн дээр дэд бүтэц эзэмшигч гүйцэтгэнэ.

НАЙМДУГААР БҮЛЭГ ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН САЛБАР ДАХЬ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИЦУУЛАЛТ

94 дугаар зүйл.Төмөр замын байгууллагын санхүү, эдийн засгийн үйл ажиллагаа

94.1.Төмөр замын байгууллага нь өмчийн хэлбэрээс үл хамааран сайн засаглал, нийгмийн хариуцлага, хүрээлэн байгаа орчныг хамгаалах бодлоготой байна.

94.2.Төмөр замын тээврийн байгууллагын санхүү, эдийн засгийн үйл ажиллагаа нь дараах зарчимд тулгуурлана:

94.2.1.төрийн зохицуулалтыг зах зээлийн үйл ажиллагаатай уялдуулах;

94.2.2.тээврийн өөрийн өртөг хамгийн бага байх;

94.2.3.зохих ашгийн түвшин бүхий үнэ, тарифын тогтолцоотой байх;

94.2.4.хэмнэлтийн тогтолцоотой байх.

95 дугаар зүйл.Тариф хэрэглэх дүрэм

95.1.Төмөр замын байгууллага тариф хэрэглэх дүрэмтэй байна.

95.2.Тариф хэрэглэх дүрмийн зорилго нь төмөр замын дэд бүтэц, хөдлөх бүрэлдэхүүний ашиглалт, засвар үйлчилгээний зардал болон хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, онцгой нөхцөлд ашиглах нөөцийн зардлыг бүрдүүлэхэд оршино.

95.3.Тариф хэрэглэх дүрмийг Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан төмөр замын тээврийн тариф тогтоох аргачлал, хэрэглэх журмыг баримтлан энэ хууль, Өрсөлдөөний тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн төмөр замын байгууллага тогтооно.

95.4.Тариф тогтоох аргачлалыг боловсруулахад дараах зарчим баримтална:

95.4.1.үйл ажиллагааны бодит өртөг, зардалд тулгуурлах;

95.4.2.Төмөр замын байгууллагын үзүүлэх үйлчилгээнд хэрэглэгчдээс тавих шаардлагатай уялдуулан хэрэглэгчийн ангилал тус бүрээр өртөг, зардлыг хуваарилах;

95.4.3.Төмөр замын байгууллагын үзүүлэх үйлчилгээний хэрэглээг зохицуулах боломжтой байх;

95.4.4.үнийг инфляцтай уялдуулан тооцох;

95.4.5.төмөр замын тээврийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл эзэмшигчийн орлого нь түүний санхүүгийн чадавхи хэвийн байлгахуйц хэмжээнд байх;

95.4.6.төмөр замын байгууллагын тогтоосон тарифын бүтэц хэрэглэгчид ойлгомжтой, энгийн байх;

95.4.7.Төмөр замын байгууллагуудын үйл ажиллагаанд техник, технологийн найдвартай, аюулгүй ажиллагааны шаардлагад нийцүүлэн хамгийн бага өртгийн зарчмыг мөрдөх;

95.4.8.тусгай зөвшөөрлийн үйл ажиллагаа явуулахад шаардагдах зардал болон оруулсан хөрөнгийн өгөөжийг тооцсон ашгийн зохих түвшинг хангасан байх;

95.5.Олон улсын харилцаан дахь тээвэрлэлтийн тариф хэрэглэх дүрмийг төмөр замын тээврийн олон улсын гэрээ, хэлэлцээрээр тогтооно.

95.6.Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь тариф, түүний бүтцийг тогтоох аргачлал, хэрэглэх журмыг батална.

95.7.Тээвэрлэгч нь зорчигч болон ачаа тээвэрлэлтийн тарифт өөрчлөлт оруулахдаа уг тарифыг мөрдөж эхлэхээс 1 сарын өмнө олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, өдөр тутмын сониноор дамжуулан тус бүр хоёроос доошгүй удаа нийтэд мэдээлнэ.

95.8.Тухайн онд мөрдөх тарифыг өмнөх оны 12 дугаар сарын 15-наас 25-ны хооронд батлан, олон нийтэд зарласан байна.

96 дүгээр зүйл.Тарифын хөнгөлөлт

96.1.Олон улсын зорчигч тээвэрлэлтийн тарифын хөнгөлөлтийг олон улсын гэрээнд нийцүүлэн Засгийн газар тогтооно.

96.2.Улсын эдийн засаг, нийгэмд онцгой ач холбогдолтой төмөр замын дэд бүтцийг зорчигч тээврийн зориулалтаар ашиглахад Засгийн газрын шийдвэрийн дагуу хөнгөлөлттэй тариф хэрэглэж болно. Уг тарифын хөнгөлөлтийн зөрүүг Төсвийн тухай хууль тогтоомжид нийцүүлэн улсын төсвөөс санхүүжүүлнэ.

96.3.Төсвийн хөрөнгөөс зорчигч тээврийн алдагдлыг нөхөх журмыг Засгийн газар тогтооно.

97 дугаар зүйл.Төрөөс төмөр замын тээвэрт үзүүлэх дэмжлэг

97.1.Нийтийн хэрэгцээний төмөр замын дэд бүтцийг хөгжүүлэх, хөдлөх бүрэлдэхүүний паркыг шинэчлэх, хэмнэлттэй, аюулгүй технологи нэвтрүүлэхэд чиглэгдсэн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлнэ.

98 дүгээр зүйл.Төмөр замын тээвэр дэх даатгал

98.1.Төмөр замын тээврийн салбарын дор дурдсан ажилтныг гэнэтийн ослын албан журмын даатгалд хамруулна:

- 98.1.1.галт тэрэгний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажилтан;
- 98.1.2.төмөр замын аюултай бүсэд ажиллаж байгаа ажилтан;
- 98.1.3.галт тэргэнд хяналт, шалгалт хийж байгаа ажилтан;
- 98.1.4.төмөр замын техник хэрэгслийг турших ажилд оролцогч ажилтан.

98.2.Энэ хуулийн 101.1-д заасан даатгалын зардлыг ажил олгогч хариуцна.

98.3.Зорчигч нь галт тэргээр зорчих хугацаанд гэнэтийн ослын даатгалд даатгуулах үүрэгтэй.

98.4.Төмөр замын дэд бүтэц, хөдлөх бүрэлдэхүүн, чингэлэг төмөр замаар тээвэрлэх ачааг хууль тогтоомжид заасан журмаар даатгалд хамруулж болно.

98.5.Төмөр замын дэд бүтцийн барилгын ажилд оролцогч нь учирч болзошгүй эрсдэлийг даатгуулж болно.

98.6.Төмөр замын дэд бүтцийн барилгын ажилд оролцогчийн буруутай үйлдлээс гуравдагч этгээдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд учирч болзошгүй хохирлыг даатгуулж болно. Даатгалыг холбогдох этгээдүүд урьдчилан тохиролцож төмөр замын дэд бүтцийн барилгын ажил гүйцэтгэх гэрээнд тусгана.

98.7.Энэ хуулийн 101.1, 101.3-д заасан даатгалын хураамжийн хэмжээг Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тогтооно. Даатгалын хураамжийн хэмжээг тогтоох аргачлалыг Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Санхүүгийн зохицуулах хороотой хамтран батална.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

99 дугаар зүйл.Төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангах үндэслэл

99.1.Төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа нь хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалах, ачаа, ачаан тээш, тээшийг цаг хугацаанд нь бүрэн бүтэн тээвэрлэх, тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогчдод аюулгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, төмөр замын дэд бүтэц, хөдлөх бүрэлдэхүүн, байгууламж, тоног төхөөрөмж, машин механизмыг гэмтэл, сааталгүй ашиглах, хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, үр дагаврыг арилгахад чиглэсэн техник, технологи, зохион байгуулалтын цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх зорилготой.

99.2.Төмөр замын тээврийн салбарт дор дурдсан чиглэлээр аюулгүй байдлын нөхцөлийг бүрдүүлсэн байна.

- 99.2.1.зорчигчийн амь нас, эрүүл мэнд;

99.2.2.ачаа, ачаан тээш, тээш тээвэрлэлт;

99.2.3.галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөн, төмөр замын тээврийн бусад хэрэгслийн хөдөлгөөн;

99.2.4.төмөр замын дэд бүтэц, хөдлөх бүрэлдэхүүн, тээвэрлэлтийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа байгууламж, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл;

99.2.5.төмөр замын ажилтны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй;

99.2.6.хүрээлэн байгаа орчны хамгаалалт.

99.3.Төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангах асуудалд дор дурдсан зүйлүүд багтана:

99.3.1.хөдөлгөөн зохицуулалт болон тээвэрлэлтийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа тээврийн болон бусад техник хэрэгслийн ашиглалтын аюулгүй байдлын эрх зүйн зохицуулалт;

99.3.2.хөдөлгөөн зохицуулалт болон тээвэрлэлтийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа тээврийн болон бусад техник хэрэгслийн ашиглалтын аюулгүй байдалтай холбоотой дүрэм, журам, зааврыг зөрчих явдлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ;

99.3.3.хөдөлгөөн зохицуулалт болон тээвэрлэлтийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа тээврийн болон бусад техник хэрэгслийн хэвийн үйл ажиллагаа, ашиглалтын аюулгүй байдлын талаарх хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт, норм нормативын хэрэгжилтийн хяналт.

100 дугаар зүйл.Төмөр замын тээврийн аюулгүй байдлын тогтолцоо

100.1.Төмөр замын тээврийн аюулгүй байдлын тогтолцоо нь төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага, нутгийн захиргааны байгууллага, төмөр замын байгууллага гэсэн бүтэцтэй байна.

100.2.Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага, нутгийн захиргааны байгууллага болон төмөр замын тээврийн төрийн захиргааны хяналтыг хэрэгжүүлэх нэгж нь энэ хуульд заасан эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

100.3.Төмөр замын байгууллага нь төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой дараах эрх, үүрэгтэй:

100.3.1.төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангах, сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хяналт тавих үүргийг төмөр замын байгууллагын дарга, захирал шууд хариуцна.

100.4.Төмөр замын тээврийн аюулгүй байдлын хяналтын талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлэх нэгжтэй байна:

100.4.1.төмөр замын байгууллагын төмөр замын аюулгүй байдлыг хангах, сүйрэл, осол, аюулгүй байдал алдагдсан үйл явдлаас урьдчилан сэргийлэх

бодлого, төлөвлөгөөг боловсруулж шаардлагатай дүрэм, журмыг шинэчлэн баталж хэрэгжүүлэх;

100.4.2.төмөр замын тээврийн тухай хууль тогтоомжийн шаардлага, стандарт, салбарын болон аж ахуйн нэгж, байгууллагын мөрдөх, дүрэм, журмын хэрэгжилтийн байдал үзлэг, шалгалт хийх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээ авах;

100.4.3.төмөр замын тээврийн тухай хууль тогтоомжийг зөрчсөн талаар илэрсэн зөрчил дутагдал, эрх бүхий этгээдийн гаргасан шаардлага, дүгнэлтийн дагуу тодорхой арга хэмжээ авах.

100.5.Төмөр замын байгууллага нь аюулгүй байдлыг хангах арга хэмжээ, түүнд шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөв, төлөвлөгөөнд тусгаж зориулалтаар нь зарцуулах үүрэгтэй.

100.6.Төмөр замын тээврийн салбарт төмөр замын тээвэр дэх сүйрэл, осол, аюулгүй байдал алдагдсан үйл явдлын үр дагаврыг арилгах, сэргээн босгох чиг үүрэг бүхий нэгж байна. Энэхүү нэгжийн дүрмийг төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, мэргэжлийн хяналтын болон онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батална.

101 дүгээр зүйл.Төмөр замын тээврийн аюулгүй байдлын шаардлага

101.1.Төмөр замын тээвэрт нийлүүлэгдэж байгаа бүх төрлийн хөдлөх бүрэлдэхүүн, чингэлэг, техник хэрэгсэл, машин механизм, төмөр дэд бүтэц, зорчигч, ачаа тээвэрлэлтийн үйлчилгээ нь энэ хууль болон холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт, бусад эрх зүйн актын шаардлагад нийцсэн байна.

101.2.Төмөр замын дэд бүтэц, хөдлөх бүрэлдэхүүний техникийн зохицуулалтыг Засгийн газар батална.

101.3.Галт тэрэгний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажилтны эрүүл мэндийн байдал нь төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон шаардлагад нийцсэн байна. Эрүүл мэндийн шаардлага нь төмөр замын ажилтан өөрийн хүлээсэн хөдөлмөрлөх үүргээ аюулгүй биелүүлэх боломжит түвшинг хангасан байна.

101.4.Төмөр замын тээвэрт экологи, гал, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, хүн амын халдваргүйжүүлэлтийн асуудлыг төмөр замын байгууллага нь Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, дүрэмд нийцүүлэн хэрэгжүүлнэ.

101.5.Хий, газрын тосны хоолой, цахилгаан, дулааны шугам, бусад байгууламжийг төмөр замтай огтлолцуулах, эсхүл төмөр замын дэргэд барих ашиглах үед тогтоосон дүрэм, журмыг биелүүлээгүйн хамтын хариуцлагыг тэдгээрийг өмчлөгч эзэмшигч нар хүлээнэ.

101.6.Энэ хуулийн 104.5-д заасан байгууламж, төхөөрөмж эзэмшигч нь төмөр замын тээврийн байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй осол, аюулын байдал үүссэн тухай төмөр замын дэд бүтэц эзэмшигчид нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

102 дугаар зүйл.Төмөр замын аюултай бүс

102.1.Галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөн, ачилт, буулгалтын ажил явагддаг, тусгай тэмдэг, тэмдэглэгээ бүхий, тусгай дэглэмээр үйл ажиллагааг нь зохицуулдаг төмөр замын дэд бүтцийн бүрдэл хэсгийг төмөр замын аюултай бүс гэнэ.

102.2.Төмөр замын аюултай бүсийн дэглэмийг төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.

103 дугаар зүйл.Төмөр замын тээврийн сүйрэл, осол, аюулгүй байдал алдагдсан үйл явдал

103.1.Төмөр замын тээврийн аюулгүй байдал алдагдсанаас үүссэн хэвийн бус нөхцөл байдлыг дор дурдсанаар ангилна:

103.1.1.сүйрэл;

103.1.2.осол;

103.1.3.аюулгүй байдал алдагдсан үйл явдал.

103.2.Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүн өөр хоорондоо болон өөр тээврийн хэрэгсэлтэй мөргөлдөх, галт тэрэгний, сэлгээний болон бусад хөдөлгөөний үед өртөө, хоорондын замд хөдлөх бүрэлдэхүүн замаас гарсны улмаас дор дурдсан хор уршиг, үр дагавар бий болсон тохиолдолд сүйрэлд тооцно:

103.2.1.нэг болон түүнээс дээш хүний амь эрсэдсэн;

103.2.2.тав ба түүнээс дээш хүний эрүүл мэнд хүнд гэмтсэн;

103.2.3.онцгой аюултай нөхцөл (түймэр, хүрээлэн буй орчин бохирдох г.м) үүсэж 10 ба түүнээс дээш тооны хүн өртсөн;

103.2.4.төмөр замын хөдлөх бүрэлдэхүүн эвдэрч гэмтэн дахин ашиглах боломжгүй болсон;

103.2.5.тодорхой газар, нутаг дэвсгэрт эд зүйл, объект эвдэрч сүйдсэнээс 100 ба түүнээс дээш тооны хүний эрүүл мэнд амь насанд аюул занал учирч тухайн газар, нутагт амьдрах боломжгүй болсон.

103.3.Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүн өөр хоорондоо болон өөр тээврийн хэрэгсэлтэй мөргөлдөх, галт тэрэгний, сэлгээний болон бусад хөдөлгөөний үед өртөөний, хоорондын замд хөдлөх бүрэлдэхүүн замаас гарсны улмаас дор дурдсан хор уршиг, үр дагавар бий болсон тохиолдлыг осолд тооцно:

103.3.1.тав хүртэлх хүн эрүүл мэндийн хувьд хүнд гэмтсэн;

103.3.2.онцгой аюултай нөхцөл (түймэр, хүрээлэн буй орчин бохирдох г.м) үүсэж 10 хүртэлх хүн өртсөн;

103.3.3.тодорхой газар, нутаг дэвсгэрт эд зүйл, объект эвдэрч сүйдсэнээс 100 хүртэлх хүний эрүүл мэнд, амь насанд аюул, занал учирч амьдрах боломжгүй болсон;

103.3.4.төмөр замын хөдлөх бүрэлдэхүүн эвдэрч гэмтэн, түүнийг сэргээх ашиглахын тулд урсгал, депо болон их засвартай дүйцэх хэмжээний засвар хийх шаардлагатай болсон;

103.3.5.гал түймэр, байгалийн гамшгийн улмаас төмөр замын дэд бүтцийн иж бүрдлийн (төхөөрөмж байгууламж) бүрэн бүтэн байдал алдагдаж, галт тэрэгний хөдөлгөөн нэг болон түүнээс дээш цагаар бүрэн зогссон;

103.3.6.төмөр замын гарам дээр хөдлөх бүрэлдэхүүн бусад төрлийн тээврийн хэрэгсэлтэй мөргөлдөж эвдэрч гэмтэн, түүнийг сэргээх, ашиглахын тулд урсгал, депо болон их засвартай дүйцэх хэмжээний засвар хийх шаардлагатай болсон;

103.3.7.аюултай ачаа тээвэрлэж буй хөдлөх бүрэлдэхүүн, чингэлэг эвдэрч гэмтсэнээс хүрээлэн буй орчин, хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулах, хор уршиг, үр дагавар нь энэ хуулийн 106.2-т заасан сүйрэлд тооцох хэмжээнд хүрээгүй бол.

103.4.Төмөр замын дэд бүтэц, хөдлөх бүрэлдэхүүний ашиглалт, хөдөлгөөний аюулгүй байдлын дүрэм, журам зөрчсөнөөс үүдэлтэй дор дурдсан тохиолдлыг аюулгүй байдал алдагдсан үйл явдал гэж тооцно:

103.4.1.бэлэн бус замналаар галт тэрэг хүлээн авах, явуулах;

103.4.2.хөдлөх бүрэлдэхүүн дор сум эргэх;

103.4.3.хүрэх өртөөнд ирэхээс өмнө техникийн гэмтлийн шалтгаанаар зорчигчийн вагон галт тэрэгнээс салгах;

103.4.4.галт тэргэн дэх хөдлөх бүрэлдэхүүний тоормосны гол хоолойн төгсгөлийн краныг хааж явуулах;

103.4.5.хөдлөх бүрэлдэхүүн дор зам төмөр хугарах;

103.4.6.галт тэрэгний бүрэлдэхүүнд буй вагоны авто угсраа өөрөө салах;

103.4.7.хоорондын замд болон завсрын өртөөнд гүүшин халсан шалтгаанаар ачааны галт тэрэгнээс вагон салгах;

103.4.8.ачаа ачих, бэхлэх техникийн нөхцөл зөрчсөн шалтгаанаар завсрын өртөөнд галт тэрэгнээс вагон салгах;

103.4.9.хөдлөх бүрэлдэхүүний авто угсраа тасрах;

103.4.10.хөдлөх бүрэлдэхүүний эд анги зам дээр унах;

103.4.11.завсрын өртөө болон хоорондын замд зорчигчийн галт тэрэгний бүрэлдэхүүнд байгаа зүтгүүр эвдрэх (энэ шалтгаанаар тусламж авч нэмэлт зүтгүүр шаардсан бол);

103.4.12.зам дээр байсан болон төмөр замын барилга ойртолтын оврын хязгаарт байсан механизм, багаж хэрэгсэл, эд зүйл, бод мал, биеэр том ан амьтныг хөдлөх бүрэлдэхүүн дайрах (мөргөсөн);

103.4.13.галт тэрэг хүлээн авах, явуулах замнал руу эсвэл хоорондын зам руу болон хөдлөх бүрэлдэхүүн өөрөө өнхөрч гарах;

103.4.14.хоорондын замаас болон салбар замаас галт тэрэг хүлээн авах, явуулах замнал руу хөдлөх бүрэлдэхүүн өөрөө өнхөрч орох;

103.4.15.хориглосон заалттай дохио болон хязгаарын шонг хөдлөх бүрэлдэхүүн өнгөрч гарах;

103.4.16.эзэлгээтэй зам дээр галт тэрэг хүлээн авах;

103.4.17.эзэлгээтэй хоорондын замд галт тэрэг явуулах;

103.4.18.зам зуурт ачаа (чингэлэг) унах, бэхэлгээ гэмтэх;

103.4.19.хөдлөх бүрэлдэхүүний цутгамал эд анги (дугуй, голын хүзүү, рам, ноён нуруу) хугарах, тасрах;

103.4.20.гэрлэн дохионы хориглосон заалтын оронд зөвшөөрсөн заалт хуурамчаар асах.

103.5.Төмөр замын тээврийн сүйрэл, осол, аюулгүй байдал алдагдсан үйл явдлыг судлах, бүртгэх, мэдээлэх, тайлагнах, үр дагаврыг арилгах, галт тэрэгний хөдөлгөөнийг сэргээх, тайлангийн маягтыг тогтоох асуудлыг төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас баталсан журмаар зохицуулна.

103.6.Төмөр замын сүйрэл, осол, аюулгүй байдал алдагдсан үйл явдал бий болоход төмөр замын дэд бүтэц эзэмшигч нь хамгийн бага хугацаанд үр дагаврыг арилгах, сэргээн босголтын ажил гүйцэтгэх, галт тэрэгний хөдөлгөөнийг сэргээх арга хэмжээг авах үүрэгтэй.

103.7.Энэ хуульд заасан төмөр замын сүйрэл, осол, аюулгүй байдал алдагдсан үйл явдал болсон тохиолдолд төрийн болон нутгийн захиргааны байгууллага Гамшгаас хамгаалах хууль, бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу ослын үр дагаврыг арилгах, төмөр замын хөдөлгөөнийг богино хугацаанд сэргээхэд бүх талын туслалцаа дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.

104 дугаар зүйл.Төмөр замын тээврийн сүйрэл, осол, аюулгүй байдал алдагдсан үйл явдлыг мэдэгдэх

104.1.Төмөр замын дэд бүтэц, хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч, тээвэрлэгч болон төмөр замын салбарт үйл ажиллагаа явуулагч этгээд нь сүйрэл, осол, аюулгүй байдал алдагдсан үйл явдал бий болсон үед төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны болон хууль, хяналт, эрүүл мэндийн байгууллагад нэн яаралтай мэдэгдэнэ.

104.2.Төмөр замын дэд бүтэц, хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч, тээвэрлэгч болон төмөр замын тээврийн салбарт үйл ажиллагаа явуулагч этгээд нь сүйрэл, осол, аюулгүй байдал алдагдсан үйл явдлын шалтгааныг илрүүлэх бүхий л арга хэмжээг авах үүрэгтэй.

105 дугаар зүйл.Төмөр замын сүйрэл, осол, аюулгүй байдал алдагдсан үйл явдлыг шинжлэн шалгах

105.1.Төмөр замын тээврийн салбарын аюулгүй байдлыг хангах, ослоос урьдчилан сэргийлэх, сүйрэл, осол, аюулгүй байдал алдагдсан үйл явдлыг шалгах, шалтгаан нөхцөлийг тогтоох, дүгнэлт гаргах, тухайн шалтгаан нөхцөлөөр дахин осол гаргахгүй байх аюулгүй ажиллагааны зөвлөмж өгөх зорилгоор шинжлэн шалгах ажиллагааг явуулна.

105.2.Шинжлэн шалгах ажиллагааг Монгол улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, хууль тогтоомжид нийцүүлэн явуулна.

105.3.Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүтцэд төмөр замын тээвэрт гарсан сүйрэл, осол, аюулгүй байдал алдагдсан үйл явдлыг шинжлэн шалгах нэгж ажиллана.

105.4.Шинжлэн шалгах ажиллагааг төмөр замын тээврийн мэргэжил эзэмшиж, 10 ба түүнээс дээш жил ажилласан, төмөр замын тээврийн сүйрэл, осол, аюулгүй байдал алдагдсан үйл явдлыг шинжлэн судлах дадлага туршлагатай шинжлэн шалгагч гүйцэтгэнэ.

105.5.Шинжлэн шалгах ажиллагаанд бие даасан байх, хараат бус байх, хууль дээдлэх зарчмыг баримтална.

105.6.Шинжлэн шалгах нэгж нь төмөр замын тээврийн сүйрэл, осол, аюулгүй байдал алдагдсан үйл явдлын талаар дүгнэлт гаргахдаа төмөр замын тээврийн захиргааны хяналтыг хэрэгжүүлж байгаа байгууллагын санал, бусад нөхцөл байдлыг харгалзан үзнэ.

105.7.Шинжлэн шалгагч нь сүйрэл, осол, аюулгүй байдал алдагдсан үйл явдал болсон газарт болон сүйрэл, осол, аюулгүй байдал алдагдсан үйл явдалтай холбоотой (өртсөн) дэд бүтэц, хөдлөх бүрэлдэхүүн, дохиоллын ажиллагаа, хөдөлгөөнийг хянах, удирдах зориулалт бүхий тоног төхөөрөмжид шууд нэвтрэх эрхтэй.

105.8.Шинжлэн шалгагч нь сүйрэл, осол, аюулгүй байдал алдагдсан үйл явдлыг судалсан тайлан үйлдэж төр засгийн байгууллага, холбогдох этгээдэд хүргүүлнэ. Галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдалтай холбоотой санал, зөвлөмжийг сүйрэл, осол, аюулгүй байдал алдагдсан үйл явдлыг судалсан тухай тайланд зайлшгүй тусгана.

105.9.Шинжлэн шалгах нэгж нь төмөр замын тээвэрт гарсан сүйрэл, осол, аюулгүй байдал алдагдсан үйл явдлын талаар жил бүр олон нийтэд тайлагнана.

105.10.Шинжлэн шалгах нэгжээс ирүүлсэн зөвлөмжийг холбогдох иргэн, аж ахуйн нэгж байгууллага заавал биелүүлэх үүрэгтэй.

105.11.Холбогдох байгууллага тайлан, зөвлөмжийг хүлээн авсан тохиолдолд тухайн сүйрэл, осол, аюулгүй байдал алдагдсан үйл явдлын шалтгаан, нөхцөлийг арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж, биелэлтийг шинжлэн шалгах нэгжид эргэж тайлагнах үүрэгтэй.

105.12.Шинжлэн шалгах нэгж, түүний шинжлэн шалгагчаас хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэн шаардлагатай туслалцаа үзүүлэх үүрэгтэй.

106 дүгээр зүйл.Онцгой нөхцөлийн үед төмөр замын тээврийг зохион байгуулах

106.1.Олон нийтийн эсэргүүцэл, байгалийн гамшиг, аюулт үзэгдэл, төмөр замын тээврийн сүйрэл, осол, аюулгүй байдал алдагдсан үйл явдал зэрэг нийгэм, байгаль, техник технологиос шалтгаалан төмөр замын тээвэрлэлтийг хэвийн

явуулах боломжгүй болсон, улс орны хэмжээнд онц байдал зарласан зэрэг шалтгаанаар төмөр замын тээвэрлэлт, галт тэрэгний хөдөлгөөнийг хязгаарлах, саатуулах, хаах зайлшгүй тохиолдлыг онцгой нөхцөл гэж үзнэ.

106.2.Эрх бүхий төрийн байгууллагаас өгсөн шуурхай үүргийн дагуу төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрийг үндэслэн онцгой нөхцөлийн үед тээвэрлэлтийг түр зогсоож болно.

106.3.Төмөр замын дэд бүтэц эзэмшигч, тээвэрлэгч онцгой нөхцөлийн үед үүссэн хор уршгийг арилгаж, хэвийн байдалд оруулах хойшлуулшгүй арга хэмжээг авах үүрэгтэй.

106.4.Төмөр замын дэд бүтэц эзэмшигч, тээвэрлэгч өөрийн зардлаар онцгой нөхцөлийн үед үүссэн хор уршгийг арилгах үүрэг бүхий бүтцийн нэгжтэй байна. Нэгж нь онцгой нөхцөлийн үед ашиглах материал, техник хэрэгсэл (сэргээн босгох галт тэрэг)-ийн нөөцтэй байна.

106.5.Онцгой нөхцөлийн үед үүссэн хор уршгийг арилгах, материал, техник хэрэгслийн нөөц бүрдүүлэх ажлыг өөр мэргэшсэн байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно.

106.6.Онцгой нөхцөл үүссэн үед төмөр замын тээвэрлэлтэд оролцогчдын эрх, үүрэг, ажиллах журмыг Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөж баталсан журмаар зохицуулна. Онцгой нөхцөлийн үед ашиглах нөөц материал, техник хэрэгслийн жагсаалтыг энэхүү журмаар батална.

106.7.Төмөр замын тээврийн онцгой нөхцөлийн үед газар нутаг, хүн амыг хамгаалах явдлыг Гамшгийн тухай хууль, дүрэмд заасны дагуу онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны болон орон нутгийн захиргааны байгууллагууд хүний амь нас, эрүүл мэнд, ачаа, тээш, ачаан тээшийн бүрэн бүтэн байдал, хөдөлгөөний аюулгүй байдалд аюул учруулсан нөхцөлийн хор уршгийг арилгахад төмөр замын дэд бүтэц эзэмшигч, тээвэрлэгчид туслалцаа дэмжлэг үзүүлнэ.

107 дугаар зүйл.Төмөр замын тээврийг дайны байдалд шилжүүлэх бэлтгэл, гамшгаас хамгаалах дайчилгаа

107.1.Энхийн цагт төмөр замын тээвэрлэлтийг дайны байдалд шилжүүлэх бэлтгэлийг хангах болон гамшгаас хамгаалах дайчилгааг хуульд нийцүүлэн зохион байгуулна.

107.2.Төмөр замын тээвэрлэлтийг дайны байдалд шилжүүлэх бэлтгэл хийх арга хэмжээг санхүүжүүлэх асуудлыг холбогдох хууль тогтоомж, дүрмээр зохицуулна.

107.3.Төмөр замын тээвэрлэлтийг дайны байдалд шилжүүлэх бэлтгэлийг хангах болон гамшгаас хамгаалах дайчилгаа явуулах ажлыг удирдлагаар хангах, бэлтгэлийн арга хэмжээг Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ.

107.4.Төмөр замын байгууллага өмчийн төрөл хэлбэрээс үл хамааран дээрх арга хэмжээг хууль тогтоомж, дүрэмд заасны дагуу хэрэгжүүлэх үүрэгтэй.

108 дүгээр зүйл.Төмөр замын тээврийн объектыг хамгаалах, тээвэрт нийтийн хэв журмыг сахиулах

108.1.Аяллын замд, төмөр замын өртөөнд ачаа болон төмөр замын дэд бүтэц, хөдлөх бүрэлдэхүүн, эд хөрөнгийг хамгаалах, төмөр замын тээвэрт гал унтраах, галын аюулаас урьдчилан сэргийлж хяналт тавих асуудлыг төмөр замын цэрэгжүүлэх хамгаалах нэгж гүйцэтгэнэ.

108.2.Цэрэгжүүлэн хамгаалах нэгжийн дүрмийг Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага цагдаагийн байгууллагатай зөвшилцөн батална.

108.3.Энэ хуулийн 111.1-д заасан ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу эрх бүхий байгууллагатай байгуулсан гэрээний үндсэн дээр зохион байгуулж болно.

108.4.Төмөр замын тээвэрт нийтийн хэв журам сахиулах, гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг цагдаагийн байгууллага, цэрэгжүүлэн хамгаалах байгууллага, төмөр замын байгууллага хамтран хэрэгжүүлнэ.

108.5.Зайлшгүй хамгаалах болон хүргэгчтэй тээвэрлэгдэх ачааны жагсаалт, тээвэрлэх журмыг Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

109 дугаар зүйл.Аюултай ачааны тээвэрлэлт

109.1.Төмөр замаар аюултай болон тусгай ачааг илгээж байгаа болон хүлээн авч байгаа эзэн нь тэдгээр ачааны тээвэрлэх, ачих, буулгах үеийн аюулгүй байдлын баталгааг гаргаж, халдваржилтын зэрэглэл тогтоох, хэмжих багаж, хэрэгсэлтэй байна. Мөн ослыг болон ослын үр дагаврыг арилгах явуулын нэгжтэй байна.

109.2.Төмөр замын дэд бүтэц эзэмшигч, тээвэрлэгч нь аюултай, тусгай ачааны тээвэрлэлтийн аюулгүй байдлыг хангах, өөрийн техникийн боломжийг ашиглан аюулын хор уршгийг арилгахад оролцох үүрэгтэй.

АРАВДУГААР БҮЛЭГ ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН САЛБАРЫН АЖИЛТНЫ ХӨДӨЛМӨРИЙН ХАРИЛЦААНЫ ОНЦЛОГ ЗОХИЦУУЛАЛТ

110 дугаар зүйл.Төмөр замын тээврийн салбарын ажилтны хөдөлмөрийн харилцааны онцлог

110.1.Төмөр замын тээвэрт салбарын ажилтны талаар дараах зарчим баримтална:

110.1.1.зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих;

110.1.2.нийгмийн түншлэлд суурилсан харилцан үр ашигтай, тэнцвэртэй харилцааг бэхжүүлэх.

110.2.Төмөр замын тээврийн салбарын ажилтны хөдөлмөр зохицуулалт, хөдөлмөрийн нөхцөл, нийгмийн баталгааг Хөдөлмөрийн тухай хууль, энэ хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомж болон хамтын гэрээгээр зохицуулна.

110.3.Төмөр замын тээврийн салбарын ажилтны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, түүнд тавих хяналт нь энэ хууль болон холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандартаар зохицуулагдана.

110.4.Төмөр замын тээврийн салбарын ажилтныг ажил үүргээс нь хамааруулан галт тэрэгний хөдөлгөөнтэй шууд холбоотой ба галт тэрэгний хөдөлгөөнтэй шууд бус холбоотой гэж ангилна.

110.5.Галт тэрэгний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажил, албан тушаалын жагсаалт, тэдгээрийн ажлын дэглэм, амралтын горим, хөдөлмөрийн нөхцөлийн онцлог, шагнал урамшуулал, сахилгын шийтгэлтэй холбоотой харилцааг Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон журмаар зохицуулна. Энэхүү журмыг боловсруулахад төмөр замын тээврийн салбарын үйлдвэрчний эвлэлийн байгууллагын саналыг харгалзана.

110.6.Галт тэрэгний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажилтанд тавигдах эрүүл мэндийн шаардлагыг энэ хуулийн 113.3-т заасан журмаар тогтооно.

110.7.Галт тэрэгний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажилтнууд анх ажилд орохдоо эмнэлгийн урьдчилсан үзлэгт, ажил гүйцэтгэх явцад хугацаат үзлэгт хамрагдсан байна.

110.8.Галт тэрэгний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажилтныг эмнэлгийн урьдчилсан болон хугацаат үзлэг, аялал ба ээлжинд гарахын өмнөх үзлэгт хамруулах асуудлыг Төмөр замын тээврийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран баталсан журмаар зохицуулна.

110.9.Зүтгүүрийн болон зорчигчийн галт тэрэгний бригадын эргэлтийн амрах байранд амрах хугацаа нь өмнөх аяллын үргэлжлэх хугацааны хагасаас багагүй буюу 3 цагаас доошгүй байна.

110.10.Машинч, туслах машинчийг шөнийн ээлжинд 2-оос илүү удаа дараалан ажиллуулахыг хориглоно.

110.11.Галт тэрэгний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажилтан албан үүргээ гүйцэтгэхдээ дүрэмт хувцас хэрэглэнэ.

110.12.Энэ хуулийн 113.11-д заасан дүрэмт хувцасны загвар, хэрэглэх журмыг Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн дэд бүтцийн болон тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч батална.

111 дүгээр зүйл. Төмөр замын тээврийн салбарын ажилтны мэргэжлийн боловсрол, сургалт

111.1.Төмөр замын тээврийн салбарын ажилтны тасралтгүй сургалт, мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох, сунгах, ахиулах, хүчингүй болгох асуудлыг төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хариуцна.

111.2.Төмөр замын тээврийн салбарын мэргэжилтэн дараах мэргэшлийн зэрэгтэй байна:

111.2.1.инженер;

111.2.2.мэргэшсэн инженер, мэргэшсэн төсөвчин;

111.2.3.зөвлөх инженер, тэргүүлэх төсөвчин.

111.3.Салбарын мэргэжилтэй ажилтан болон мэргэжилтний сургалт, мэргэшлийн зэрэг олгохтой холбоотой харилцааг төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмаар тогтооно.

111.4.Төмөр замын тээврийн салбарын ажилтны мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох асуудлыг гэрээний үндсэн дээр төрийн бус, мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж болно.

111.5.Галт тэрэгний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажилтны мэргэжил дээшлүүлэх зардлыг ажил олгогч хариуцна.

111.6.Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагч, галт тэрэгний машинчийг сургах, давтан сургах, мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөрт санал өгөх, шалгалт авах, үнэмлэхжүүлэх асуудлыг Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын төв хариуцна.

112 дугаар зүйл.Галт тэрэгний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажилтны хөдөлмөрийн сахилга

112.1.Галт тэрэгний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажилтанд Хөдөлмөрийн хуульд зааснаас гадна дор дурдсан сахилгын арга хэмжээг ногдуулна.

112.1.1.төмөр замын хөдөлгөөний бус ажилд 1 жил хүртэл хугацаагаар шилжүүлэх.

113 дугаар зүйл.Төмөр замын байгууллагын ажилтны нийгмийн баталгаа

113.1.Төмөр замын байгууллагын ажилтан дор дурдсан нийгмийн баталгаагаар хангагдана:

113.1.1.Галт тэрэгний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажилд 25-аас доошгүй жил ажилласан эрэгтэй, 20-иос доошгүй жил ажилласан эмэгтэй өндөр насны тэтгэвэр тогтоолгохдоо арван найман сарын дундаж цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламж авах;

113.1.2.Галт тэрэгний хөдөлгөөнтэй шууд бус холбоотой ажилд 25-аас доошгүй жил ажилласан эрэгтэй, 20-иос доошгүй жил ажилласан эмэгтэй төмөр замын байгууллагаас тэтгэвэр тогтоолгосон бол есөн сарын дундаж цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламж авах;

113.2.Монгол Улсын нутаг дэвсгэрийн дотор төмөр замаар аялах тохиолдолд жилд нэг удаагийн аяллын ирэх, очих замд галт тэргээр үнэгүй зорчих.

113.3.энэ хуулийн 116.1.1, 116.1.2, 116.2-т заасан нийгмийн баталгаатай холбогдон гарах зардлыг ажил олгогч хариуцна.

113.4.Төмөр замын байгууллага нь өмчлөлийн хэлбэрээс үл хамааран хамтын гэрээнд заасны дагуу өндөр насны тэтгэвэрт гарсан, ажил эрхэлдэггүй ахмад настанд нийгмийн дэмжлэг үзүүлж болно.

113.5.Төмөр замын салбарын ажилтан сайн дурын үндсэн дээр олон давхаргат тэтгэврийн тогтолцоонд хамрагдаж болно. Энэ тогтолцоог нэвтрүүлэх ажлыг төмөр замын байгууллага хэрэгжүүлнэ.

113.6.Төмөр замын алслагдсан цэгүүдэд байнга болон явж ажилладаг ажилтнуудад дэмжлэг олгох асуудлыг Төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан журмаар зохицуулна.

АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН САЛБАРЫН БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА

114 дугаар зүйл.Төмөр замын дэд бүтэц, хөдлөх бүрэлдэхүүн, түүний эд анги, эдлэхүүнийг үйлдвэрлэх, угсрах, сэргээх, засварлах

114.1.Төмөр замын дэд бүтэц, хөдлөх бүрэлдэхүүн, түүний эд анги, эдлэхүүнийг үйлдвэрлэх, угсрах, сэргээх, засварлах ажлыг төрөөс баримтлах бодлогод нийцүүлэн, өндөр үр ашиг бүхий дэвшилтэт технологийг нэвтрүүлэх зорилгоор энэ хуулийн 34.2-т заасан тусгай зөвшөөрлийн үндсэн дээр гүйцэтгэнэ.

114.2.Төмөр замын дэд бүтэц, хөдлөх бүрэлдэхүүн, түүний эд анги, эдлэхүүнийг үйлдвэрлэх, угсрах, сэргээх, засварлах үйл ажиллагаа нь Үйлдвэржилтийг дэмжих тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль, энэ хууль холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт, төмөр замын олон улсын гэрээ, стандарт, төслийн бичиг баримтын шаардлагад нийцсэн байна.

115 дугаар зүйл.Хот, дүүргийн төмөр замын зорчигч тээвэр

115.1.Хот, дүүргийн зорчигч тээвэрт метро, хөнгөн галт тэрэг болон тэдгээртэй адилтгах төмөр замын бусад хөдлөх бүрэлдэхүүнийг ашиглан тээвэрлэлт хийх үйл ажиллагааг Засгийн газраас баталсан дүрмээр зохицуулна.

116 дүгээр зүйл.Төмөр замын тээврийн олон улсын хамтын ажиллагаа

116.1.Монгол Улс нь төмөр замын тээврийн олон улсын хамтын ажиллагаанд оролцохдоо нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, олон улсын хэм хэмжээ, Монгол Улсын олон улсын гэрээг дагаж мөрдөнө.

116.2.Олон улсад төмөр замын тээврийн эрх ашгийг төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон хуулиар зохих бүрэн эрх олгогдсон төрийн захиргааны болон бусад байгууллага төлөөлж хэрэгжүүлнэ.

117 дугаар зүйл.Төмөр замын тээвэрт баримтлах цаг

117.1.Төмөр замын тээвэрлэлтийн ажиллагааг харилцан уялдуулан, тасралтгүй удирдлагаар хангах зорилгоор Монгол Улс дахь төмөр замын тээвэрт Улаанбаатарын цагийг нэгдсэн журмаар баримтална.

118 дүгээр зүйл.Төмөр замын тээвэрт хэрэглэх хэл

118.1.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол төмөр замын тээврийн байгууллага өмчийн төрөл, хэлбэрээс үл хамааран үйл ажиллагаа, албан хэргийг төрийн албан ёсны хэлээр хөтлөн явуулна.

118.2.Төмөр замын өртөө, зөрлөг, зорчигчид үйлчлэх цогцолбор, бусад газарт зорчигч болон ачаа илгээгч, хүлээн авагчид шаардлагатай мэдээллийг төрийн албан ёсны хэлнээс гадна өөр хэлээр хүргэж болно.

119 дугаар зүйл.Төрийн бус байгууллагын оролцоо

119.1.Төмөр замын төрийн бус байгууллага төмөр замын тээврийн тухай хууль тогтоомж, төмөр замын тээврийн нийтлэг багц дүрэм, стандартын хэрэгжилтийг боловсронгуй болгох, үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулахад идэвхтэй үйл ажиллагаа явуулна.

119.2.Төрийн бус байгууллага нь төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон төрийн захиргааны байгууллагын зарим чиг үүргийг гэрээний үндсэн дээр гүйцэтгэж болно.

120 дугаар зүйл.Төмөр замын тээврийн үйл ажиллагаанд бусад иргэн, хуулийн этгээд дэмжлэг үзүүлэх

120.1.Хүний амь нас, эрүүл мэнд, ачаа, тээш, ачаан тээш, хөдөлгөөний аюулгүй байдалд хохирол учруулах нөхцөл байдлын үр дагаврыг арилгахад холбогдох төрийн захиргааны болон орон нутгийн эрх бүхий байгууллага, аж ахуйн нэгж, иргэн туслах үүрэгтэй.

121 дүгээр зүйл.Хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

121.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтанд Төрийн албаны тухай хууль, иргэн, хуулийн этгээдэд энэ хууль, Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хуульд заасан хариуцлага болон энэ хууль, Иргэний хуульд заасан эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэнэ.